

*ИОН намын дахин, дэлгэрэнгүй
хэлэлцүүлэгтэй ээлжит бус гуравдугаар
их хурлын 2025 оны 10 сарын 19-ний өдрийн
04 дүгээр тогтоолын хавсралт*

*(ИОН намын Төлөөлөгчдийн Танхимын
2025 оны 11 сарын 12-ны өдрийн 3-р хурлын
3 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан)*

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН ДҮРЭМ

(шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. дүгээр зүйл. Дүрэм, дүрмийн зорилт

- 1.1 Энэхүү Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрэм (цаашид **“Намын дүрэм”** гэх)-ийг Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон холбогдох бусад журамтай нийцүүлэн боловсруулж, дүрмийн төсөлд Намын үүсгэн байгуулагч гишүүдийн саналыг авч улмаар ИОН нам үүсгэн байгуулах хурлаар танилцуулж, баталсан болно.
- 1.2 Намын дүрмээр Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд тус намд элсэх, намын гишүүнээс түдгэлзүүлэх, гарах, гишүүдийн эрх үүргийг тогтоох, намын үйл ажиллагааг удирдах бүтэц зохион байгуулалтыг байгуулах, намын үйл ажиллагааг төлөвшүүлэх хийгээд намын дотоод бүртгэл, гишүүний татвар, хандив, дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам нь (цаашид ИОН нам эсхүл Нам гэх)
 - 1.3.1 Тодорхойлолт: Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам нь Монгол улсын тусгаар тогтнол, бие даасан урт хугацааны тогтвортой хөгжлийг иргэдийн идэвхтэй оролцоо, эрх, эрх чөлөөний тусламжтайгаар буй болгож баталгаажуулахыг зорьж буй, баруун төвийн үзэл санааг баримталсан Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн чөлөөт, сайн дурын нэгдэл юм.
 - 1.3.2 Намын албан ёсны нэрийг бүтнээр “Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам” гэх ба “ИОН нам” гэж товчилно. Англиар “The Civic Unity Party” гэх ба “CUP” гэж товчилно.
 - 1.3.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын бэлгэдэл нь мөнх тэнгэрийг харуулсан цэнхэр дэвсгэр дээр Монгол орны дөрвөн зүг, найман зовхисоос иргэд эрх чөлөөтэй, эвлэлдэн нэгдэж эх орондоо хөгжил дэвшил авчирч, дээшлэн дэвжиж байхыг цагаан өнгийн гар гараасаа хөтлөлцсөн найман хүний дүрээр

харуулж, иргэдийнхээ идэвхтэй оролцоогоор өнөд хамгаалагдаж бэхжих тусгаар тогтнол, төрт ёс, хууль ёсыг төвдөө алтан тойрогт залрах соёмбо тэмдгээр илэрхийлэн дүрсэлсэн байна.

- 1.3.4 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын далбаа нь хэмжээнийхээ гуравны нэгийг эзэлсэн төв хэсэгт ИОН намын бэлгэдлийг багтаасан цэнхэр өнгөтэй байна. Далбааг хэвтээ болон босоо хэлбэрээр хэрэглэж болох бөгөөд аль ч тохиолдолд бэлгэдлийн төв хэсэгт байрлах алтан соёмбо нь дээш харсан байна.
- 1.3.5 Намын домэйн нэр нь www.cup.mn байна.
- 1.4 Намын нэр, далбаа, бэлгэдэл, домэйн нэр нь холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн буюу баталгаажсан даруйдаа намын оюуны өмч болно. Тэдгээрийн эх загварыг энэхүү Дүрмийн Хавсралт 1-д заав.
- 1.5 Нам нь өөрийн бэлгэдлийг дүрсэлсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр болон бэлгэдэл бүхий лого, тэмдэгтэй байна.
- 1.6 Энэхүү Намын дүрэмд үндэслэн Намын дүрэм хэрэгжүүлэх аргачлалыг Төлөөлөгчдийн Танхим батална.
- 1.7 ИОН нам нь дүрмээ баррель үсгээр хэвлүүлнэ. Сонсдог хэлбэрээр нийтэлнэ.
- 1.8 Энэхүү дүрмийн аль ч зүйл хэсгийг мушгин тайлбарлахгүй бөгөөд дараах хэм хэмжээний дэс дарааллыг баримтална. Үүнд:
 - 1.8.1 Намын үзэл баримтлал, үнэт зүйл;
 - 1.8.2 Үйл ажиллагааны зарчим;
 - 1.8.3 Намын дүрмийн тухайлсан зохицуулалт;
 - 1.8.4 Төлөөлөгчдийн танхимаар баталсан журам.

2 дугаар зүйл. Намын үзэл баримтлал, үнэт зүйл.

- 2.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам нь баруун төвийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэгч нам болохын хувьд дараах үнэт зүйлтэй байна. Үүнд:
 - 2.1.1 Монгол Улсын аюулгүй байдал, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол бол ИОН намын нэн тэргүүний язгуур үнэт зүйл мөн.
 - 2.1.2 Ардчилал, олон намын тогтолцоо, парламентын засаглал, хүний эрх, эрх чөлөө нь ИОН намын тууштай хамгаалах ёстой үнэт зүйл мөн.

- 2.1.3 Хувийн өмч, хувийн хэвшил нь улс орны эдийн засгийн хамгийн тогтвортой бат бэх үндэс бөгөөд эдийн засгийн чөлөөт байдалд төрийн оролцоо хязгаарлагдмал байх бодлогыг баримтална.
- 2.1.4 Үндэсний өв соёлоо хамгаалж судлах, өвлөн тээх, дамжуулан уламжлуулах, орчин үеийн Монгол үндэсний бахархал, соёлыг бүтээлцэх нь ИОН намын гишүүн бүрийн эрхэмлэх үнэт зүйл мөн.
- 2.1.5 Ил тод байдал, иргэний оролцоо, хэмнэлттэй байдал, улс төрийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ нь ИОН намын гишүүн бүрийн болон намын үйл ажиллагааны үнэт зүйл мөн.
- 2.1.6 Хуулийн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, улс орны тогтвортой хөгжлийг бий болгох, Монгол оронд хүн шударгаар ажиллаж амжилтад хүрч, аз жаргалтай амьдарч болох хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох нь бидний үнэт зорилт мөн.
- 2.1.7 Гадаад харилцаанд олон талт, энх тайванч, найрсаг хөршийн бодлогыг тууштай дэмжиж, бусад улс төрийн намуудтай гадаад харилцааны асуудлаар зөрчилдөхөөс сэргийлж, Монгол Улсын нэгдмэл гадаад бодлогыг баталгаажуулах нь намын үнэт зүйл мөн.
- 2.1.8 Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх, үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн олон талт асуудлаар нийтийн боловсролыг байнга нэмэгдүүлэх замаар ирээдүйн зардлыг бууруулах нь намын бодлогын чухал хэсэг мөн.
- 2.1.9 Уламжлалт мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, аялал жуулчлал зэрэг олон салбарын суурь нь болсон байгаль орчин, бэлчээр, ус, ой, газрын баялагтай холбоотой аливаа чиглэлд ИОН нам тогтвортой хөгжил, хариуцлагатай хэрэглээ, ил тод байдал, нийтийн эрх ашиг - хувийн өмчийн эрхийн тэнцвэртэй харилцаа, ирээдүйд үлдээх нөөц, нөхөн сэргээлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх явдлыг үнэт зүйл гэж үзнэ.
- 2.1.10 Нийгмийн харилцааны бүхий л оролцогчдын хөгжих, хөгжлийн үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэдний амьдрах орчны эрүүл аюулгүй байдлыг сайжруулах нь ИОН намын үнэт зүйл мөн.
- 2.1.11 Нам нь эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эрх, үүрэг, боломж эдлүүлнэ.
- 2.1.12 Үзэл бодлоо илэрхийлэх үйл ажиллагааг зохистой арга хэлбэрээр зохион байгуулж, нийгмийн дэг журам, аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахыг эрхэмлэнэ.
- 2.1.13 Намын дотоод сонгуулийг нээлттэй, тэгш шударга зохион байгуулна.

3 дугаар зүйл. Намын үйл ажиллагааны зарчим

3.1 Нам үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтална:

- 3.1.1 ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх;
- 3.1.2 үйл ажиллагаагаа ил тод явуулах;
- 3.1.3 гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, аливаа сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох;
- 3.1.4 дотоод асуудлаа шийдэхдээ нийтийн зарыг хүртээмжтэйгээр түгээж, хурал, сонгуульд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;
- 3.1.5 бусад намын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, өөрийн үзэл баримтлалыг тулган шаардахгүй байх;
- 3.1.6 үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулах;
- 3.1.7 Монгол Улсаас гадаад улстай тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг эрхэмлэн хүндэтгэх.
- 3.1.8 ИОН нам нь оюуны өмч, оюуны бүтээлийг ямагт хүндэтгэн үйл ажиллагаандаа албан ёсны лиценз зөвшөөрөлтэй бараа бүтээгдэхүүн, программ, үйлчилгээг хэрэглэнэ. Үүнд намын хөрөнгөөс зарцуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ авах тухай хуулийн дагуу нээлттэй ил тод зохион байгуулна.
- 3.1.9 ИОН нам нь орчин үеийн мэдээллийн технологийн шийдэл, гар утас болон таблетын аппликэйшн, веб сайт, цахим шууданг өдөр тутмын үйл ажиллагаанд өргөнөөр хэрэглэж, гишүүдийн оролцоог орон зай, газар зүйн байрлалаас үл хамааран хүртээмжтэй зохион байгуулна. Эдгээр технологийг ашиглан гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.

4 дүгээр зүйл. Намд элсэх, намаас гарах, түдгэлзэх, намаас хасах, сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл

4.1 ИОН нам нь гишүүдийнхээ өмнө гаргах баталгаа:

- 4.1.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намд эвлэлдэн нэгдсэн, намын үйл хэргийг олон нийтэд таниулахаар ажилласны төлөө болон гишүүний хувьд иргэнийг мөшгөн хавчих, заналхийлэх, гүтгэх, доромжлох, дарамтлах зэргээр хууль бус үйлдэл гаргасан бол ИОН намын энэ дүрэмд заасан бүтцийн байгууллага, албан тушаалтан гишүүнийхээ эрхийг хамгаалж, мэдэгдэл гаргана.

- 4.1.2 Намын гишүүний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ИОН намын гишүүн болох талаар тодорхойлолтыг хэнд ч гаргахгүй. Гэхдээ Намын гишүүдэд нээлттэй аппликэйшн, веб сайт, намын дотоод бүртгэлийн мэдээлэл үүнд хамаарахгүй.
- 4.1.3 Намын гишүүнийг бодлого, зарчим баримтлах, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн өрсөлдөөнд оролцох зэрэг улс төрийн эрхээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан аливаа шийтгэл хүлээлгэхгүй. Намын албан тушаалаас огцруулах, үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, хариуцлага тооцох нь зөвхөн энэ Намын дүрэм, түүний хүрээнд баталсан журмаар заасан хэм хэмжээний хүрээнд байна.
- 4.2 Монгол Улсын сонгуулийн насны эрх бүхий иргэн сайн дураар ИОН намд элсэнэ. Намд элсэхдээ дараах бүртгэлийн аль ч хэлбэрээр бүртгүүлж болно. Үүнд:
- 4.2.1 Цахим орчинд байрлах Намын албан веб сайтад нийтлэгдсэн намын аппликэйшнийг ашиглаж бүртгэлийн өргөдлийг зааврын дагуу бөглөж илгээх, эсхүл
- 4.2.2 Өөрийн оршин суугаа газрын байрлалаас үл хамааран намын гүйцэтгэх байгууллага оршин байгаа байранд биеэр ирж бичгээр өргөдөл гаргах.
- 4.3 Цахимаар буюу өөрийн биеэр ирж өргөдөл гаргасны дагуу ИОН намын бүртгэгч (цаашид **Бүртгэгч** гэх) өргөдлийг системд оруулан намын аппликэйшн дээр дахин давтагдашгүй хувийн код үүсгэж, намын гишүүний цахим профайл үүссэнээр тухайн өргөдөл гаргагч ИОН намд элссэнд тооцогдоно.
- 4.4 Өөр намын гишүүнийг ИОН намд гишүүнээр бүртгэхгүй. Хэрэв Намд шинээр бүртгүүлсэн хүн өөр намын гишүүнээс гарах өргөдлөө тус намын төв буюу, эсвэл орон нутгийн харьяаллын анхан, дунд аль нэг шатны байгууллагад цахимаар илгээх буюу биечлэн хүлээлгэн өгсөн бол тус өдрөөс эхлэн шинээр бүртгүүлсэн хүнийг ИОН намд элссэн гэж үзэн Намын үйл ажиллагаанд оролцох оролцоог гишүүний эрх, үүргийн дагуу тооцно.
- 4.5 ИОН намын гишүүнээр элссэн хүн өөр намын бүртгэлээс хасагдсан эсэхээс үл хамааран тухайн намаас гарах өргөдлөө өгсөн огноогоор тооцож ИОН нам шинэ гишүүн гэж үзнэ. ИОН намаас гарах өргөдөл өгсөн хүнд энэ зарчим бас хамаарах бөгөөд намын бүртгэлээс хасагдсан эсэхээс үл хамааран өргөдөл гаргагчийг өргөдөл гаргасан өдрөөс ИОН намаас гарсан гэж үзнэ.
- 4.6 Хуульд заасны дагуу төрийн зарим албан тушаалтан, албан хаагчийг намаас дараах журмыг баримтлан түдгэлзүүлнэ. Үүнд:
- 4.6.1 ИОН намын гишүүн хуульд намаас түдгэлзэхээр заасан аливаа албан тушаалд сонгогдсон, томилогдсон бол уг сонгуулийн дүн, томилгоог албажуулсан төрийн байгууллагын тогтоол, шийдвэрийг үндэслэл болгон Бүртгэгч “Намаас түдгэлзүүлэх

тухай” акт үйлдэж, намаас түдгэлзэж буй гишүүнд цахимаар, эсхүл шуудангаар бичгээр илгээнэ. Тус актад гишүүнийг намаас түдгэлзүүлж буй хуулийн тодорхой заалт, намын цахим бүртгэлд гишүүний төлөвийг “идэвхгүй” хэлбэрт шилжүүлсэн тухай, төрийн албан үүргээс чөлөөлөгдсөн өдрөөс эхлэн намын гишүүнчлэлээ сэргээх хүсэлтийг Бүртгэгчид болон намын ажлын албанд гаргах эрхтэй болохыг тус тус заавал дурдана.

- 4.6.2 Намаас түдгэлзсэн гишүүний эрхэлж буй намын албан тушаал, сонгуульт орон тоонд тус гишүүнийг намаас түдгэлзсэн өдрөөс эхлэн орон гарсанд тооцогдоно.
- 4.6.3 Намаас түдгэлзсэн гишүүн нь түдгэлзсэн хугацаандаа намын дотоод үйл ажиллагаанд оролцохгүй.
- 4.6.4 Намаас түдгэлзсэн гишүүн төрийн албан үүргээс чөлөөлөгдсөн өдрөөс эхлэн намын гишүүнчлэлээ сэргээх хүсэлтийг Бүртгэгчид болон намын ажлын албанд бичгээр гаргана. Энэхүү хүсэлтийг үндэслэн намын гишүүнчлэлийг сэргээсэн тухай актыг Бүртгэгч үйлдэж, намын цахим бүртгэлд гишүүний төлөвийг “идэвхитэй” хэлбэрт шилжүүлнэ.
- 4.6.5 Намаас түдгэлзсэн гишүүн намын гишүүнчлэлээ сэргээсэн нь түүний намын өмнөх сонгуульт болон бусад албан тушаал, эрх мэдлийг сэргээх үндэслэл болохгүй. Намын гишүүнчлэлээ сэргээснээр гишүүн намын аливаа дотоод сонгуульд нийт гишүүдэд нээлттэй арга хэлбэрээр оролцоно.
- 4.7 Намын гишүүнийг дор дурдсан зөрчил гаргасан нь үндэслэлтэй гэж Маргаан Таслах Комиссын хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол гишүүнд намаас хасахыг сануулах, намаас төрийн сонгуульд нэр дэвших эрхийг нэг сонгуулийн жил хасах, эсхүл хасахыг сануулах, намын дотоод сонгуульд нэр дэвших эрхийг 1-3 жил хасах, намаас хасах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Үүнд:
 - 4.7.1 Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгын аливаа үйл ажиллагаанд ИОН намын нэр, туг, бэлгэдлийг ашигласан;
 - 4.7.2 Намын аль нэг бүтэц, удирдлагын сүлжээ, гишүүдийн баг бүрэлдэхүүнийг шашны, цэргийн, цэрэгжсэн байгууллага болгохыг завдсан;
 - 4.7.3 Фашист үзэл санааг дэмжиж сурталчилсан бол тус тус намаас хасах үндэслэл болно.
 - 4.7.4 Дээрх үйлдэлд хуулийн хариуцлага хүлээх бол тухайн асуудал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ.

- 4.7.5 Нам улс төрийн мэдэгдэл гарган оролцож, дэмжиж буй аливаа жагсаал цуглаан, сонгуулийн сурталчилгаа, арга хэмжээний үеэр нам албан ёсоор хамтарч буй этгээдийнхээс өөр этгээдийн туг далбаа, билэг тэмдэгийг ашиглаж оролцсон, намын туг далбаа, билэг тэмдэг, нэрийг ашиглан намын албан ёсны байр суурийг үгүйсгэсэн мэдэгдэл хийсэн бол гишүүнийг төрийн сонгуульд нэр дэвших эрхийг нэг сонгуулийн жилд хасахыг сануулах, эсхүл хасах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.
- 4.7.6 Энэ дүрмийн 12.5.1, 12.5.2, 16.13, 13.9, 15.5.3-т заасан зөрчлөөс үүдэж эрх нь зөрчигдсөн намын гишүүний Маргаан таслах комисст гаргасан гомдол үндэслэлтэй гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийн намын дотоод сонгуульд нэр дэвших эрхийг 1-3 жилийн хугацаатай хасна.
- 4.7.7 ИОН Намаас нэр дэвшиж сонгогдон төрийн улс төрийн албан тушаалд ажиллаж буй гишүүн намын байр суурь хурлын тогтоол хэлбэрээр албажсан аливаа асуудал дээр тус байр суурийн эсрэг санал өгсөн бол намаас хасахыг сануулах сахилгын шийтгэл ногдуулна.
- 4.7.8 Маргаан таслах комиссын шийдвэрээр ногдуулсан сахилгын шийтгэлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн сахилгын шийтгэлээр хязгаарлагдсан байсан гишүүний эрх сэргээгдсэнд тооцно.
- 4.7.9 Намын гишүүнд тооцох сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацаа нь дор дурдсан хэмжээтэй байна. Үүнд:
- 4.7.9.1 Намаас хасах заалт бүхий сахилгын шийтгэл оногдуулах зөрчлийг хөөн хэлэлцэх хугацаа зөрчил гарснаас хойш 1 жилийн дотор;
- 4.7.9.2 Намаас хасахаас бусад заалт бүхий сахилгын шийтгэл оногдуулах зөрчлийг хөөн хэлэлцэх хугацаа зөрчил гарснаас хойш 3 сарын дотор.
- 4.8 Намын гишүүн хэдийд ч сайн дураар Намаас гарч болно. Намаас гарахдаа:
- 4.8.1 Намын Бүртгэгчийн албан ёсны цахим шуудангийн хаяг руу өөрийн цахим хаягаас гараар бичсэн өргөдлийг илгээх, эсхүл
- 4.8.2 Оршин суугаа газрын байрлалаас үл хамааран намын албан ёсны хаяг бүхий аль ч байранд биеэр ирж гараар бичсэн өргөдлийг гаргана.
- 4.9 Энэ дүрмийн 4.8.1 болон 4.8.2-т заасан өргөдлийг намын Бүртгэгчийн цахим шуудангийн хаяг руу илгээснээр, эсхүл намын төв болон орон нутгийн аливаа салбарын удирдлагад бичгээр хүлээлгэн өгснөөр намаас гарсанд тооцогдоно.
- 4.10 Намаас гарсан тухай мэдээллийг өргөдөл хүлээн авсан намын хариуцлагатай албан тушаалтан намын мэдээллийн санд тэр даруй оруулахаар Бүртгэгчид илгээх ба зөвхөн Бүртгэгч гишүүний мэдээллийг намын бүртгэлээс хасалт хийнэ.
- 4.11 Намын Бүртгэгчийн албан ёсны цахим шуудангийн хаягаар намаас гарах өргөдлийг хүлээн авсан бол гишүүний харьяалагдаж буй салбар, төлөөлөгчийн танхимд хариуцаж буй дарга нарт мэдэгдэнэ.

- 4.12 Намын гишүүнээр элсээгүй Монгол улсын иргэн намын дэмжигч байж болно. Намын дэмжигч нь намын гишүүдийн нээлттэй уулзалт, сургалт, үйл ажиллагаанд хамрагдах, намын хуралд ажиглагчаар оролцох эрхтэй. Намын дэмжигч нь намын орон нутгийн салбар байгууллагад бүртгэлтэй байж болно.

5 дугаар зүйл. Намын гишүүн, түүний төрөл

- 5.1 Намын гишүүд өөрийн нэрээр элсэж, өөрийн нэрийн өмнөөс Намын үйл хэрэгт оролцоно.
- 5.2 Намын гишүүн бүр энэхүү Намын дүрмийг зөвшөөрч, дагаж мөрдөх үүрэгтэй.
- 5.3 Намын гишүүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, намын үйл ажиллагаанд тэгш оролцох, намын бүтцийн байгууллагад сонгож, сонгогдох эрхтэй ба намын татвар төлөх, хууль тогтоомж болон намын дүрэмд захирагдах, намын дүрэм журмаар тогтоосон бусад үүргийг биелүүлэх үүрэгтэй.
- 5.4 Намын гишүүн энэ дүрмийн 5.3-т заасан татвар төлөх үүргийг биелүүлэхээс түдгэлзэж намын “ажиглагч гишүүн” болж болно. Ажиглагч гишүүн нь намын гишүүний жилийн татварын хэмжээ 0-ээс дээш төгрөгөөр тогтоогдсон нөхцөлд татвар төлөөгүй хугацаандаа намын хуралд санал таслах эрхгүй байх бөгөөд харин намын бүтцийн байгууллагад сонгогдох, намын үйл ажиллагаанд тэгш оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь байнга хадгалагдана.
- 5.5 Намын гишүүн тухайн жилийн татвараа төлсөн бол тухайн календарийн жилд “татвар төлөгч гишүүн” статустай байх бөгөөд намын аливаа хуралд татвар төлөгч гишүүн санал таслах эрхтэй байна. Хэрэв тухайн календарийн жил намын нийт гишүүдийг татвараас чөлөөлсөн, намын татварын хэмжээг “0”-тэй тэнцүү хэмжээгээр тогтоосон бол намын бүх гишүүд татвар төлөгч гишүүний эрхийг эдэлнэ.
- 5.6 Намын гишүүн нь жилийн татвараас гадна, намын дансанд хандив өгсөн бол хандив өгснөөс хойш 12 сарын хугацаанд “хандивлагч гишүүн” гэж тооцогдоно.
- 5.7 Хандивлагч гишүүн нь энэхүү дүрмийн 5.3-т заасан гишүүний эрхээс гадна зөвхөн хандивлагч гишүүдийн дунд явагдах санал асуулгад оролцох эрхтэй байна.
- 5.8 Тухайн жилийн гишүүний татварын хэмжээнээс илүү хандив өгсөн хандивлагч гишүүн бүр татвар төлөгч гишүүн гэж тооцогдоно.
- 5.9 Намын ажиглагч, татвар төлөгч, хандивлагч гишүүд нь улс төрийн сонгуульд нэр дэвшихээр бэлтгэж буй бол улс төрийн зорилготой хуримтлалын нэрийн данстай байх ба нэрийн хуримтлалын дансаа Бүртгэгчид бүртгүүлсэн гишүүнийг хуримтлал бүрдүүлэгч гишүүн гэнэ.
- 5.10 Хуримтлал бүрдүүлэгч гишүүн нь намд өөрийн хуримтлалын 1 хувиас илүүгүй, хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр жилд нэг

удаа “хуримтлалын татвар” төлсөн бол энэ дүрмийн 5.3, 5.5-д заасан эрх, үүргээс гадна төрийн улс төрийн албан тушаал, сонгуульд намаас нэр дэвшигчийг бэлтгэх сургалт, шалгаруулалт, тандалт үнэлгээнд хамрагдах эрхтэй.

6 дугаар зүйл. Намд хориглох зүйлс, Намын гишүүний болон төрийн албан хаагчийн үүргийг зааглах

- 6.1 Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэний намд албадан элсүүлэх болон намаас гарахыг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 6.2 ИОН нам нь төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно.
- 6.3 ИОН нам хамт олон дунд хөгжиж төрийн жинхэнэ албан хаагч болсон аливаа ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийг чанд баримтлах бөгөөд албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэгэн намын, тэр тусмаа өөрийн харьяалагдаж байсан энэхүү намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно.
- 6.4 ИОН намаас нэр дэвшин сонгогдсон, томилогдсон төрийн жинхэнэ албан хаагч өөрийн албан тушаалын хүрээнд хамаарах албан үүрэг гүйцэтгэхдээ намын эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргах, сурталчилгаа хийх, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хориглоно.
- 6.5 ИОН нам нь шашны байгууллагын үйл ажиллагаанд болон боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаанд оролцохгүй. Гэхдээ намын гишүүн шашин шүтэх эс шүтэх, эрхээ эдлэхэд энэ заалт хамаарахгүй.
- 6.6 Хуулиар хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.
- 6.7 Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг, фашист намтай нэгтгэх, нийлэхийг хориглоно.
- 6.8 Намын удирдлага, санхүүгийн албаны дарга, ерөнхий менежер, түүнтэй адилтгах албан тушаалтан нь аль нэгэн улс төрийн сан, нийгэмлэг, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн нөөц захиран зарцуулах эрх бүхий албан тушаал эрхлэхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НАМЫН САЛБАР, ТАНХИМ, НАМЫН ДЭРГЭДЭХ

БАЙГУУЛЛАГА, АЖЛЫН АЛБА БАЙГУУЛАХ

7 дугаар зүйл. Намын анхан шатны салбар, дунд шатны танхим байгуулах

- 7.1 Намын анхан шатны салбар байгуулахыг хүссэн ИОН намын гишүүн аль нэг сум, хороонд бүртгэлтэй гишүүдийн нэрсийн жагсаалтыг, дунд шатны танхим байгуулахыг хүссэн сум, хорооны салбарын дарга, эсхүл намын Төлөөлөгчдийн танхимын аль нэг гишүүн тухайн орон нутагт байгуулагдсан бүх анхан шатны салбарын танхимын гишүүдийн нэрсийг тус тус Бүртгэгчээс авч, салбар, танхим үүсгэн байгуулах хурлын байр эсхүл цахим хурлын линк, өдөр, цагийг товлосон зарыг хурал болохоос 24 цагаас багагүй хугацааны өмнө Бүртгэгчээс хүлээж авсан жагсаалт дахь нийт гишүүдэд хүргэнэ.
- 7.2 Дараах шаардлагыг хангасан бол дор дурдсан этгээд нутаг дэвсгэрийн харьяаллаар намын салбарыг сум, хороонд байгуулж болно. Үүнд:
- 7.3 Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын сум, хорооны салбарыг тухайн сум, хороонд 10-аас доошгүй тооны иргэн намын аппликэйшн татаж энэ дүрмийн 5.1 дэх шаардлагыг хангаж бүртгүүлсэн бол намын гишүүний санаачилсан салбар байгуулах хурлаар дараах нууц санал хураалтыг явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 7.3.1 Намын сум, хорооны салбар байгуулах;
 - 7.3.2 Намын сум, хорооны салбарын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох;
 - 7.3.3 Сум, хорооны Танхимын гишүүдийг сонгох;
 - 7.3.4 Намын сум, хорооны салбарын албан ёсны байрны хаягийг батлах;
- 7.4 Салбар байгуулсан хурлын тогтоолыг сонгогдсон анхан шатны салбарын дарга намын Бүртгэгчид хаяглан ирүүлнэ. Бүртгэгч нь салбар үүсгэн байгуулах хүсэлтийг нягталж, салбарыг албажуулах тухай тушаалын төслийг Намын даргад уламжилна.
- 7.5 Аймаг, дүүргийн хоёр ба түүнээс дээш тооны сум, хороонд Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын салбар байгуулагдсан бол тухайн аймаг, дүүргийн харьяа аль нэг сумын салбарын дарга, эсхүл ИОН намын төлөөлөгчдийн танхимын гишүүн аймаг, дүүргийн салбар байгуулах хурлыг товлон зарлаж, удирдаж болно. Аймаг, дүүргийн танхим байгуулах хурлаар дараах асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 7.5.1 Аймаг, дүүргийн Танхим байгуулах;
 - 7.5.2 Аймаг, дүүргийн Танхимын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох;
 - 7.5.3 Аймаг, дүүргийн Танхимын гишүүдийг батлах;
 - 7.5.4 Аймаг, дүүргийн Танхимын албан ёсны байрны хаягийг батлах;

- 7.6 Танхим байгуулсан хурлын тогтоолыг сонгогдсон Танхимын дарга намын Бүртгэгчид хаяглан ирүүлнэ. Бүртгэгч нь Танхим үүсгэн байгуулах хүсэлтийг нягталж, танхимыг албажуулах тухай тушаалын төслийг Намын даргад уламжилна.
- 7.7 Намын дарга нь сум, хорооны салбар, аймаг, дүүргийн танхимын үйл ажиллагааг албажуулахтай холбоотой дараах тушаалыг гаргана. Үүнд:
- 7.7.1 Шинээр байгуулагдсан салбар, танхимыг албажуулах,
 - 7.7.2 Шинээр сонгогдсон салбар, танхимын даргад намын холбогдох тамга, албан бичгийн хуудас ашиглах зөвшөөрөл олгох,
 - 7.7.3 Маргаан таслах комиссын шийдвэрийг үндэслэн салбар, танхим албажуулсантай холбоотой намын даргын тушаал, эсхүл тушаалын тодорхой хэсгийг хүчингүй болгох.

8 дугаар зүйл. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага, сонирхлын бүлэг байгуулах

- 8.1 Намын үнэт зүйл, үзэл баримтлалын хүрээнд бодлогын стратеги, тактик боловсруулах, судалгаа хийх, намын гишүүдийг сургах, иргэдэд улс төрийн боловсрол түгээх эрхэм зорилго бүхий намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:
- 8.1.1 Нам нь дэргэдээ бодлогын судалгааны байгууллагатай байна.
 - 8.1.2 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага нь сангийн хэлбэртэй байж болох ба тогтмол үйл ажиллагаа явуулна.
 - 8.1.3 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд зохих хууль, журмын дагуу бүртгүүлэх бөгөөд Менежментийн зөвлөлөөр ИОН намын дэргэд ажиллахаар батлагдсаны дараа уг байгууллагыг намын Бүртгэгч бүртгэнэ.
- 8.2 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага нь удирдлагаа дотооддоо бие даан сонгож, санхүүгийн асуудал хариуцсан захирал, нягтлан бодогч нарыг намын Бүртгэгчид бүртгүүлнэ.
- 8.3** Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага Улс төрийн намын тухай хуулийн дагуу ИОН нам төрөөс санхүүжилт авсан тохиолдолд энэ дүрмийн дагуу хуваарилагдах санхүүжилтийн эх үүсвэрт тохируулан үйл ажиллагаа явуулах ба ИОН нам тус байгууллагыг бүрэн санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй.
- 8.4 ИОН намын болон төрийн санхүүжилтээр хийсэн ажил, судалгаа, сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Менежментийн зөвлөлийн хурлаар, бодлогын судалгааны үр дүнг Үнэт зүйлийн зөвлөлийн хурлаар тус тус сонсож, хэлэлцэнэ.

- 8.5 Бодлогын судалгааны байгууллагын намын дэргэд үйл ажиллагаа явуулах хугацаа нь 4 жил байна. Энэхүү хугацааг Менежментийн зөвлөлийн хурлын шийдвэрээр 4 хүртэлх жилээр тухай бүр сунгаж болно.
- 8.6 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага орон тооны судалгааны 2 ажилтантай байх ба захиалгат ажил гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт ажилтанг гэрээгээр түр ажиллуулж болно.
- 8.7 Намын гишүүд нийгэмд тулгамдсан асуудалд намын үнэт зүйлийн хүрээнд шийдэл хайхаар нэгдэж, тодорхой сэдэв, нийгмийн бүлгийн хүрээнд тогтмол бус үйл ажиллагаа бүхий сонирхлын бүлэг, клуб байгуулан ажиллаж болно. Сонирхлын бүлэг, клубыг байгуулсан, татан буулгасан тухай шийдвэр, тухайн сонирхлын бүлэг, клубын ахлагч, санхүү хариуцах гишүүнийг тус хурлыг удирдсан гишүүн намын Бүртгэгчид бүртгүүлнэ.

9 дүгээр зүйл. Намын байр, ажлын алба байгуулах, албан харилцааны хэрэгсэл

- 9.1 Намын байр, веб сайт, дотоод харилцаа холбооны аппликэйшн зэрэг дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг ерөнхий менежер, салбар, танхимын байр зохион байгуулах ажлыг холбогдох салбар, танхимын дарга тус тус хариуцна.
- 9.2 Нам болон түүний салбар, танхимын нэр дээр үл хөдлөх хөрөнгө худалдан авахыг хориглоно.
- 9.3 Салбар, танхимын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах цахим болон харилцаа холбооны бусад арга хэрэгслийг гишүүн бүрд хүртээмжтэй ашиглах боломжтой нөхцөлд намын салбар, танхимын үйл ажиллагааг зөвхөн шаардлагатай тохиолдолд түр байранд ажиллах горимоор зохион байгуулж болно.
- 9.4 Намыг төлөөлж төрийн байгууллагатай харилцах албан харилцаанд намын албан хуудас, тамга ашиглах ба гишүүд, дэмжигчидтэй харилцах албан харилцаанд намын албан ёсны цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон бусад зөвшөөрөгдсөн харилцааны хэрэгсэл ашиглаж болно. Гэхдээ энэ нь үүсэж болох болзошгүй нөхцөл байдалд өөр арга хэрэгсэлээр харилцах харилцааг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.
- 9.5 Намын тамга, албан хуудас гээгдэж үрэгдэх буюу хуурамчаар үйлдэгдэх, цахим хуудас болон цахим харилцааны бусад хэрэгслэл халдлагад өртөх үед зөвхөн намын даргын гарын үсэг бүхий баримт бичгийг гадагш чиглэсэн албан харилцаанд хэрэглэнэ.
- 9.6 Гадаад улс, гадаадын байгууллагатай Нам харилцахад зөвхөн даргын гарын үсэгтэй албан бичиг, даргын албаны цахим шуудан ашиглана. Энэ эрхийг дарга өөрөө хэрэгжүүлэх боломжгүй байвал Намын дэд даргад бичгээр, түр эрх шилжүүлэн өгч болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

10 дугаар зүйл. Их Хурал

- 10.1 Намын эрх барих дээд байгууллага нь Намын Их хурал байна.
- 10.2 Намын ээлжит их хурал гурван жил тутамд тухайн жилийнхээ 3-р сарын сүүлийн долоо хоногт хуралдана. Намын их хурлыг зохион байгуулахад дараах дараалал, эрх, үүргийн хуваарийг баримтална:
- 10.2.1 Намын дарга Намын ээлжит их хурлыг 60-аас доошгүй хоногийн өмнө товлож, гурав хоногийн дотор намын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээн дэх намын хамгийн олон дагагчтай хуудсаар нийт гишүүдэд зарлана. Намын ээлжит их хурлын тов тогтоосон шийдвэрт намын их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж оруулна.
- 10.2.2 Намын ээлжит их хурлыг товлон зарласнаас хойш Намын их хурал эхлэхээс 72 цагийн өмнөх хүртэлх хугацаанд багтаан намын ээлжит их хурлын төлөөлөгч сонгох сум, хорооны салбарын гишүүдийн хурлыг сум, хорооны салбарын дарга зарлан хуралдуулж, төлөөлөгч сонгосон тогтоолыг Намын их хурал зохион байгуулах ажлын хэсэгт хүргүүлнэ.
- 10.2.3 Намын их хурлын төлөөлөгч сонгох салбарын гишүүдийн хурлын тов тогтоох, зарыг санал таслах эрхтэй гишүүнд хурал эхлэхээс дор хаяж нэг өдрийн өмнө түгээхийг сум, хорооны Салбарын дарга, сонгогдсон төлөөлөгч нарт намын их хурлын тов, цахимаар оролцох линкийг намын их хурал болохоос гурваас доошгүй хоногийн өмнө илгээхийг Намын их хурал зохион байгуулах ажлын хэсэг тус тус хариуцна.
- 10.3 Намын их хурлын чөлөөт суудалд намын анхан шатны салбараас Төлөөлөгчдийн танхимын тогтоосон ижил тэнцүү тоогоор төлөөлөгч сонгоно. Намын их хурлын чөлөөт бус суудалд намын дарга, намын дэд дарга, төлөөлөгчдийн танхимын дарга, маргаан таслах комиссын гишүүд, намын ерөнхий менежер, бүртгэгч томилолтоор орно.
- 10.4 Намын их хурлын нийт төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байна.
- 10.5 ИОН намын салбаргүй сум, хорооноос намын их хуралд оролцохоор гишүүн хүсэлт гаргаж Намын их хурал зохион байгуулах ажлын хэсэгт бичгээр буюу цахим шуудангаар хүргүүлж болно. Намын их хурлыг зохион байгуулах ажлын хэсэг уг хүсэлтийг Намын их хурал эхлэхээс 72-24 цагийн өмнөх хугацаанд хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Салбаргүй сум, хорооноос оролцох их хурлын төлөөлөгчдийн тоо нь салбарын хурлаас сонгогдсон төлөөлөгчдийн 10 хувиас хэтрэхгүй байна.

- 10.6 Намын дүрэм, үйл ажиллагааг Монгол улсын хуулийн заалтад тодорхой тогтоосон хугацаанд багтаан нийцүүлэх шаардлага үүссэн, намын даргын орон гарсан тохиолдолд ээлжит бус их хурал хуралдаж болно. Намын ээлжит их хурлын төлөөлөгч нь дараагийн ээлжит хурлын тов батлагдах хүртэлх хугацаанд болох намын ээлжит бус их хурлын төлөөлөгч байна. Намын даргын орон гарсан үед ээлжит бус их хурлыг Намын дэд дарга товлон зарлана.
- 10.7 Намын ээлжит бус их хурлыг 30-аас доошгүй хоногийн өмнө товлон зарлаж, хурлын зарыг тус их хуралд оролцох эрх бүхий төлөөлөгчдөд энэхүү дүрмийн 27.2-т заасан арга хэлбэрээр тов гарснаас хойш долоо хоногийн дотор хүргэнэ. Намын ээлжит их хурлын төлөөлөгч нас барсан, намаас гарсан тохиолдолд холбогдох салбарын бүх гишүүдийн хурлаас ээлжит бус их хуралд төлөөлөгч нөхөн сонгож болно.
- 10.8 Дараах асуудлыг зөвхөн намын Их хурлаар хэлэлцэн, хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, батална:
- 10.8.1 Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтыг батлах;
 - 10.8.2 Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 10.8.3 Намын Төлөөлөгчдийн танхим болон Маргаан Таслах Комиссын тайланг гурван жил тутам хэлэлцэх, тэдгээрийн бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх, нөхөн сонгох;
 - 10.8.4 Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, намын нэрийг өөрчлөх.
 - 10.8.5 Намын дарга, дэд даргыг нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох;
 - 10.8.6 Монгол улсын хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 10.9 Намын ээлжит болон ээлжит бус их хуралд сонгогдсон төлөөлөгчдийн олонх тус хурлын ирсэн ирцийг бүрдүүлснээр хурал хүчинтэйд тооцогдоно.
- 10.10 Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах төслийг Төлөөлөгчдийн танхимын 8 ба түүнээс дээш тооны гишүүн, Маргаан таслах комисс, Менежментийн зөвлөл тус тус санаачилж болох бөгөөд төслийг Их хуралд Намын дарга оруулна.
- 10.11 Намын их хурлаар хэлэлцэх асуудлыг намын даргын оруулсан санал, тус хуралд оролцсон төлөөлөгчдийн гаргасан нэмэх, хасах, өөрчлөх саналыг тус тус үндэслэн намын их хурлын төлөөлөгчдийн олонхийн саналаар батална.

11 дүгээр зүйл. Төлөөлөгчдийн танхим

- 11.1 Намын Их хурлын чөлөөт цагт Намыг Төлөөлөгчдийн танхим удирдана. Төлөөлөгчдийн танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 11.2 Төлөөлөгчдийн танхим нь намын төлөөллийн төв байгууллага мөн. Төлөөлөгчдийн танхим ээлжит дотоод сонгуультай жилийн гуравдугаар сард, ээлжит дотоод сонгуультай эсэхээс үл хамааран жил бүрийн 12 дугаар сард хуралдана.
- 11.3 Төлөөлөгчдийн танхим нь нийтлэг суудалд нэр дэвшиж сонгогдсон 30 эрэгтэй, 30 эмэгтэй, жендер харгалзахгүй 3, аймаг, дүүргийн суудалд нэр дэвшиж сонгогдсон 2 эрэгтэй, 2 эмэгтэй, нийслэлийн суудалд нэр дэвшиж сонгогдсон 5 эмэгтэй, 5 эрэгтэй, нийгмийн бүлгийн төлөөллийн суудалд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 2 эрэгтэй, 2 эмэгтэй (дохионы хэлний орчуулагчийг оруулахгүйгээр) нараас тус тус бүрдэнэ.
- 11.4 Төлөөлөгчдийн танхимын гишүүнд нэр дэвших эрх нийт гишүүдэд нээлттэй байх бөгөөд энэхүү дүрмийн 20.6-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Дотоод сонгуулийн ажлын хэсэг нэр дэвшигчдийг нийтлэг зарын дагуу бүртгэж, Төлөөлөгчдийн танхимын гишүүнд нэр дэвшигчийг намын их хуралд оруулна.
- 11.5 Намын Төлөөлөгчдийн Танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж, Төлөөлөгчдийн танхимын хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 11.5.1 Төлөөлөгчдийн танхимын даргыг нууц санал хураалтаар нэг жилийн хугацаагаар сонгох, чөлөөлөх, огцруулах.
- 11.5.2 Менежментийн зөвлөлийн гишүүдийг 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох;
- 11.5.3 Намын Бүртгэгчийг 5 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх, огцруулах;
- 11.5.4 Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг дотоод аудиторыг 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар томилох, чөлөөлөх, нэг удаа дахин томилох, нөхөн томилох;
- 11.5.5 Дотоод сонгуулийн ажлын хэсгийг нэг жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгож байгуулах, ажлын хэсгийг 6 хүртэл удаа улируулан сонгох, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
- 11.5.6 Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх.
- 11.5.7 Намын дүрмийн гуравны нэг хүртэлх заалтад бүрэлдэхүүнийхээ гуравны хоёрын саналаар нэмэлт, өөрчлөлт оруулах.

- 11.5.8 Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль, Засгийн Газрын томилгооны үйл явцад нам дангаараа эсхүл өөр намтай эвсэл байгуулж, эсхүл өөр нам эвслийг дэмжиж оролцох эсэх;
- 11.5.9 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын сонгууль, нөхөн сонгуульд намаас нэр дэвшигчийг нууц санал хураалтаар сонгож батлах;
- 11.5.10 Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр батлах;
- 11.5.11 Энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах “Дүрэм хэрэгжүүлэх заавар”, болон хууль тогтоомж, энэхүү дүрмээр тусгайлан заасан журмыг батлах;
- 11.5.12 Жил бүрийн 12 дугаар сарын 31-нээс өмнө дараа жилийн төсвийг баталж, тухайн жилд төлөх гишүүний татварын хэмжээг тогтоох;
- 11.5.13 Өмнөх жилийн 12 сарын 15-наас тухайн жилийн 1 дүгээр сарын 31-ний хооронд тухайн календарийн жилд болох ээлжит дотоод сонгуулийн нэгдсэн товыг батлах;
- 11.5.14 Монгол улсын хууль, энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 11.6 Энэ дүрмийн 11.5-д заасан Төлөөлөгчдийн танхимын анхны даргыг сонгох Төлөөлөгчдийн танхимын хурлыг Намын дарга товлон зарлаж, Төлөөлөгчдийн танхимын даргыг сонгох шийдвэр гартал тус хурлыг удирдана. Төлөөлөгчдийн танхимын дарга сонгогдмогцоо бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.
- 11.7 Төлөөлөгчдийн танхимын дарга дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
- 11.7.1 Төлөөлөгчдийн танхимын анхны даргыг сонгох хурлаас бусад Төлөөлөгчдийн танхимын хурлыг таваас доошгүй хоногийн өмнө, яаралтай хурлыг 24 цагийн өмнө тус тус товлон зарлах, зарыг санал таслах эрхтэй гишүүдэд намын цахим системд бүртгэлтэй имейл хаягаар тов гарснаас хойш 20 цагийн дотор хүргүүлэх, хурлыг удирдах; хурал даргалах эрхийг шилжүүлэх шаардлагатай гэж үзвэл хурлын дарга тэргүүлэгчийг санал оруулах;
- 11.7.2 Төлөөлөгчдийн танхимын хурлыг удирдах, хурлын шийдвэрт гарын үсэг зурах;
- 11.7.3 Төлөөлөгчдийн танхимын хурлын бэлтгэл ажлыг удирдах, бэлтгэл ажил хангах ажлын хэсгийг томилох, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах
- 11.7.4 Энэхүү дүрэм, дүрэм хэрэгжүүлэх зааварт тусгасан асуудал, цагийн хуваарийг баримталж ажиллах;
- 11.7.5 Намын даргыг түр орлож буй намын дэд дарга тус үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл энэ дүрмийн 15.15-д заасан үндэслэлээр үүссэн тохиолдолд намын ээлжит бус их хурлыг товлон зарлах, удирдах, хурлын шийдвэрт гарын үсэг зурах, хурлын шийдвэрийг намыг төлөөлөн төрийн байгууллагад хүргүүлэх;

- 11.7.6 Намын дотоод аудиторын албан тушаалд нийцэх мэргэжил, ур чадварын шаардлага хангасан нэр дэвшигчийг Төлөөлөгчдийн танхимаар томилох, дотоод аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх, дахин томилох, нөхөн томилох асуудлыг тус тус Төлөөлөгчдийн танхимын хуралд оруулж хэлэлцүүлэх;
- 11.7.7 Монгол улсын хууль, энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх
- 11.8 Төлөөлөгчдийн танхимын дарга сонгох дотоод сонгуульд жил бүрийн 12 дугаар сард Төлөөлөгчдийн Танхимын хурлаар явагдана. Төлөөлөгчдийн танхимын даргын сонгуулийг Дотоод сонгуулийн ажлын хэсэг удирдан явуулна. Төлөөлөгчдийн танхимын даргад Төлөөлөгчдийн танхимын гишүүн өрсөлдөнө.
- 11.9 Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн 8 хувиас багагүй нь намын даргад итгэл үзүүлэх эсэх талаар санал хураалт явуулахыг бичгээр шаардсан бол Төлөөлөгчдийн танхимын хурлыг уг шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан хуралдуулж, намын даргад итгэл үзүүлэх эсэхийг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 11.10 Төлөөлөгчдийн танхимын гишүүн бүрэн эрхийнхээ хугацааг дуусахаас өмнө намаас гарах, өөрийн хүсэлтээр Төлөөлөгчдийн танхимын гишүүнээс чөлөөлөгдөх, намаас хасагдах, намаас түдгэлзэх тохиолдолд түүний орон гарсан суудалд нөхөн сонгуулийг зохион байгуулна.

12. дугаар зүйл. Сум, Хорооны Бүх гишүүдийн хурал, сум, хорооны танхим, салбарын дарга

- 12.1 Сум, хорооны салбарын бүх гишүүдийн хурал нь гишүүд намын анхан шатанд оролцоогоо илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэх гол талбар бөгөөд тухайн засаг захиргааны нэгж дэх намын үйл ажиллагааг удирдана. Сум, хорооны бүх гишүүдийн хурал жил бүр хуралдаж дараах асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 12.1.1 Намын орон нутгийн анхан шатны төлөөллийн байгууллага болох сум, хорооны танхимыг бүх гишүүдийн хурлаас 3-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, гурван жилийн бүрэн эрхтэйгээр байгуулах, түүний бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгох, өөрчлөлт оруулах, чөлөөлөх;
- 12.1.2 Сум, хорооны салбарын даргыг гурван жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох;
- 12.1.3 Сум, хорооны салбарын байрыг батлах, өөрчлөх;
- 12.1.4 Намын ээлжит их хурлын төлөөлөгчийг нууц санал хураалтаар сонгох, нөхөн сонгох;
- 12.1.5 Аймаг, дүүргийн танхимын гишүүнийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох.

- 12.1.6 Сум, хорооны Танхим нь сум хорооны бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт намын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллана. Сум, Хорооны танхимыг сум, хорооны салбарын дарга тэргүүлнэ.
- 12.2 Сум, хорооны Танхим нь хагас жил тутамд хуралдаж, олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
- 12.2.1 Сум, хорооны салбарын төсвийг батлах, өөрчлөлт оруулах;
- 12.2.2 Намын ээлжит их хурлын төлөөлөгчид орон гарсан тохиолдолд намын ээлжит бус их хурлын төлөөлөгчийг нууц санал хураалтаар сонгох;
- 12.2.3 Аймаг, дүүргийн Танхимд бүрэн эрхийн хугацаанаас өмнө орон гарсан тохиолдолд гишүүнийг нөхөн нууц санал хураалтаар сонгох;
- 12.2.4 Сум, хорооны төрийн улс төрийн албанд намаас нэр дэвшүүлэх;
- 12.2.5 Сум түүний баг, нийслэлийн хорооны түвшинд явагдаж буй төрийн сонгуульд нам оролцох, бусад намтай эвсэх эсэхийг шийдвэрлэх, тус сонгуульд намын баримтлах мөрийн хөтөлбөрийг батлах;
- 12.2.6 Сум хорооны салбарын санхүү, үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах;
- 12.2.7 Монгол улсын хууль, энэхүү дүрэм, түүний хүрээнд гарсан журамд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 12.3 Сум, хорооны Бүх гишүүдийн хурал болон Танхимын гүйцэтгэх алба нь сум, хорооны ажлын алба байна. Ажлын албыг сум, хорооны салбарын дарга, эсхүл түүний томилсон менежер удирдаж болно. Ажлын албанд салбарын даргын томилсон санхүүч байх бөгөөд ажлын албаны данс Намын Санхүүчид бүртгэлтэй байна.
- 12.4 Сум, хорооны салбарын дарга нь дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
- 12.4.1 Салбарын бүх гишүүдийн хурал, салбарын танхимын хурлыг товлон зарлах, удирдах;
- 12.4.2 Салбарын ажлын албыг байгуулах, ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;
- 12.4.3 Монгол улсын хууль, энэхүү дүрэм, түүний хүрээнд гарсан журамд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 12.5 Сум, хорооны салбарын дарга намын гишүүдийн сонгох, сонгогдох эрхийг дараах байдлаар зөрчсөн нь түүнийг огцруулах үндэслэл болно. Үүнд:
- 12.5.1 Намын их хурлын төлөөлөгч, аймаг, дүүргийн танхимын гишүүн сонгох асуудлыг хэлэлцүүлэхээр Төлөөлөгчдийн Танхимаас ерөнхий товыг баталсан салбар, танхимын хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр батлагдсан хугацаанд товлон зарлаагүй, товлон зарласан хуралдаа оролцоогүй, удирдаж

хийлгэсэн хурлын шийдвэрийг намын зохих ажлын хэсэгт хугацаанд нь илгээгээгүй.

- 12.5.2 Сум, хорооны сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлаар хуулиар тогтоосон хугацаанд холбогдох хурлыг товлон зарлаагүй, товлон зарласан хуралдаа оролцоогүй, удирдаж хийлгэсэн хурлын шийдвэр, хуулиар заасан бусад баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбоотой тайланг төрийн зохих байгууллагад хуулийн хугацаанд илгээгээгүй.
- 12.6 Энэ дүрмийн 12.5-д заасан салбарын даргыг огцруулах үндэслэл гарсан тохиолдолд Салбарын бүх гишүүдийн хурлыг намын даргын томилсон хурал зохион байгуулагч товлон зарлаж, хурлыг удирдаж, салбарын даргыг огцруулах эсэх, шинээр салбарын дарга сонгох эсэх асуудлыг тус тус хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

13. дугаар зүйл. Аймаг, Дүүрэг, Нийслэлийн Танхим, танхимын дарга, ажлын алба

- 13.1 Аймаг, дүүрэг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй анхан шатны салбарын ажлын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, гишүүдийн сонгох, сонгогдох эрхийг аймаг, дүүргийн түвшинд хангах, намын үйл ажиллагааг тухайн дэвсгэрт удирдах үүрэгтэйгээр Аймаг, Дүүрэг, Нийслэлийн Танхим ажиллана.
- 13.2 Аймаг, дүүргийн танхим нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
- 13.2.1 Аймаг, дүүргийн танхимыг анхан шатны хоёр салбар нэгдэж байгуулсан тохиолдолд тус салбарын танхимын гишүүд,
- 13.2.2 Аймаг, дүүргийн танхимыг гурав ба түүнээс дээш тооны анхан шатны салбар нэгдэж байгуулсан, эсхүл ээлжит хурлын өмнө тус аймаг, дүүрэгт ийм тооны анхан шатны салбартай болсон бол аймаг, дүүргийн танхимыг аймгийн төвөөс бусад сумын салбар тус бүрээс сонгогдсон 1 эмэгтэй, 1 эрэгтэй гишүүн; аймгийн төвийн сум, хотын салбараас сонгогдсон 2 эмэгтэй, 2 эрэгтэй гишүүн, дүүргийн хороо тус бүрээс сонгогдсон 1 эрэгтэй, 1 эмэгтэй гишүүн бүрдүүлнэ.
- 13.3 Аймаг, дүүргийн Танхимын шинээр сонгогдсон бүрэлдэхүүний анхны хурлыг аймаг, дүүргийн салбарын дарга, даргыг сонгоогүй, эсхүл хүндэтгэх шалтгаанаар намын ажлаас чөлөө хүссэн, нас барсан, гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон бол тус тус Намын даргын тушаалаар томилогдсон салбарын даргын үүрэг гүйцэтгэгч товлон зарлаж хуралдуулна.
- 13.4 Нийслэлийн Танхимыг дүүргийн салбарын дарга нар, нийслэлийн танхимын дарга бүрдүүлнэ. Нийслэлийн танхимын даргаар дүүргийн салбарын дарга давхар ажиллахыг хориглоно.

- 13.5 Нийслэлийн Танхимын анхны хурлыг Намын дарга товлон зарлана. Нийслэлийн танхимын анхны хуралдааныг дүүргийн салбарын дарга нарын хамгийн ахмад нь даргална.
- 13.6 Нийслэлийн Танхимын анхны хуралдаанаас дараах шийдвэрийг нууц санал хураалтаар гаргана. Үүнд:
- 13.6.1 Намын нийслэлийн танхим байгуулах;
 - 13.6.2 Нийслэлийн танхимын даргыг сонгох;
 - 13.6.3 Нийслэлийн танхимын албан ёсны байрны хаягийг батлах.
- 13.7 Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 13.7.1 Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын даргыг гурван жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох, улируулах, чөлөөлөх;
 - 13.7.2 Аймаг, дүүрэг, нийслэлийн иргэдийн төлөөллийн байгууллагад намаас нэр дэвшигчийг нууц санал хураалтаар тодруулах;
 - 13.7.3 Аймаг, дүүрэг, нийслэлийн түвшинд явагдаж буй төрийн сонгуульд оролцох, сонгуульд өөр намтай эсвэл болж оролцох эсэх, сонгуульд намын баримтлах мөрийн хөтөлбөрийг батлах;
 - 13.7.4 Аймаг, дүүрэг, нийслэлийн салбарын төсвийг батлах, өөрчлөлт оруулах;
 - 13.7.5 Аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын санхүү, үйл ажиллагааны нэгтгэсэн тайланг хэлэлцэж, батлах
 - 13.7.6 Монгол Улсын хууль тогтоомж, намын дүрэм, журмаар тусгайлан заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.
- 13.8 Аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын дарга холбогдох танхимын хурлыг товлон зарлах, удирдах бүрэн эрх, үүрэгтэй байх ба намын санхүү, эд хөрөнгө захиран зарцуулах эрхгүй байна.
- 13.9 Аймаг, дүүрэг, нийслэлийн түвшний сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлэх хурлыг хуулийн хугацаанд товлон зарлаагүй, товлон зарласан хуралдаа оролцоогүй, удирдаж хийлгэсэн хурлын шийдвэр, хууль тогтоомжид заасан баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбогдуулан гаргах санхүүгийн тайланг төрийн зохих байгууллагад хуулийн хугацаанд илгээгээгүй нь аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын даргыг огцруулах үндэслэл болно.
- 13.10 Энэ дүрмийн 13.9-т заасан огцруулах үндэслэл гарсан тохиолдолд аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын хурлыг намын даргын томилсон хурал зохион байгуулагч товлон зарлаж, хурлыг удирдаж, танхимын даргыг огцруулах эсэх, шинээр танхимын дарга сонгох эсэх асуудлыг тус тус хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

13.11 Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын гүйцэтгэх алба нь аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын ажлын алба байна. Ажлын албыг аймаг, дүүрэг, нийслэлийн Танхимын даргын томилсон менежер удирдах бөгөөд ажлын албаны санхүү, эд хөрөнгийг захиран зарцуулна. Ажлын албанд менежерийн томилсон санхүүч байх бөгөөд ажлын албаны данс ИОН намын Бүртгэгчид бүртгэлтэй байна. Аймаг, дүүргийн ажлын албаны менежерийн томилсон санхүүч нь сум, хорооны салбарын санхүү, үйл ажиллагааны тайланг нэгтгэж намын Санхүүчид илгээх үүрэгтэй.

14. дүгээр зүйл. Менежментийн Зөвлөл

14.1 Менежментийн зөвлөл нь ИОН намын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах гүйцэтгэх төв байгууллага мөн.

14.2 Менежментийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Менежментийн зөвлөлийн гишүүнд нэр дэвших эрх нийт гишүүдэд нээлттэй байх бөгөөд энэхүү дүрмийн 14.5-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Дотоод сонгуулийн ажлын хэсэг Менежментийн зөвлөлд нэр дэвшигчийг Төлөөлөгчдийн танхимын хуралд оруулж дотоод сонгуулийг удирдан явуулна.

14.3 Менежментийн зөвлөл нь намын Ерөнхий менежерийг оролцуулан 7 гишүүнтэй байх ба аль нэг хүйсийн төлөөлөл нийт бүрэлдэхүүний 40 хувиас багагүй байна.

14.4 Менежментийн зөвлөлд Намын дарга, дэд дарга, Төлөөлөгчдийн танхимын дарга орж болохгүй.

14.5 Менежментийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

14.5.1 Намын дотоод үйл ажиллагааг хууль тогтоомж, намын дүрэм, журманд заасан цаг хугацаанд зохион байгуулахад шаардлагатай удирдлагаар хангах, холбогдох намын албан тушаалтан, орон нутгийн намын байгууллага, намын ажлын албанд үүрэг чиглэл, зөвлөмж өгөх.

14.5.2 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг батлах, намын дэргэд ажиллах бүрэн эрхийн хугацааг батлах, сунгах, үйл ажиллагааны тайланг сонсох.

14.5.3 Намын ерөнхий менежерийг дундаасаа нууц санал хураалтаар 4 жилийн хугацаагаар сонгох, 3 хүртэл удаа улируулан сонгох, огцруулах, чөлөөлөх,

14.5.4 Намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэхээс нэгээс доошгүй хоногийн өмнө хэлэлцэх. Санхүүгийн тайланг хэлэлцэхэд Ерөнхий менежерийн танилцуулга, Дотоод аудиторын санал дүгнэлтийг тус тус сонсох.

14.5.5 Энэхүү дүрэм, Төлөөлөгчдийн Танхимаас баталсан төсвийн хүрээнд намын бүтцийн байгууллага, салбар, танхимаас ирүүлсэн төсөл хөтөлбөрийг хэлэлцэх, өөрчлөлт оруулах, батлах, санхүүжүүлэх эрхийг ерөнхий менежерт олгох,

- 14.5.6 Намын үйл ажиллагаа, санхүүд хийсэн дотоод аудиторын хяналт шалгалтын дүнг авч хэлэлцэх, аудиторын зөвлөмж дүгнэлтийн дагуу авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлж холбогдох үүрэг чиглэл өгөх, хугацаат ажлын төлөвлөгөө батлах. Шаардлагатай гэж үзвэл тус асуудлаар Төлөөлөгчдийн Танхимын хуралд асуудал хэлэлцүүлэхээр санаачилж, Төлөөлөгчдийн Танхимын даргад төслийг хүргүүлэх.
- 14.5.7 Намын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах.
- 14.5.8 Монгол улсын хууль, намын дүрэм, журамд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 14.6 Менежментийн зөвлөл зөвлөл хагас жил тутам хуралдаж олонхын саналаар шийдвэр гаргана. Менежментийн зөвлөлийн хурлыг Ерөнхий менежер зарлан хуралдуулна.
- 14.7 Менежментийн зөвлөлийн гишүүдийг дараах тохиолдолд чөлөөлж, нөхөн сонгууль явуулж болно.
 - 14.7.1 Нас барсан
 - 14.7.2 Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн
 - 14.7.3 Намаас гарах хүсэлт гаргасан
 - 14.7.4 Намаас түдгэлзэх зэрэг тодорхой шалтгааны улмаас 1-ээс дээш жилийн хугацаанд ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон
- 14.8 Менежментийн зөвлөлийн гишүүн тус зөвлөлийн хурлыг 4 удаа дараалан тасалсан нь түүнийг огцруулах үндэслэл болно.

15. дугаар зүйл. Намын дарга, дэд дарга

- 15.1 Намын дарга нь намыг гадаад, дотоодод төлөөлнө.
- 15.2 Намын даргыг гурван жилийн хугацаагаар Намын Их Хурлаас нууц санал хураалтаар сонгох ба намын даргыг 3 хүртэл удаа улируулан сонгож болно. Намын даргын бүрэн эрх дараагийн даргыг намын Их Хурлаар сонгосон тогтоол батлагдсанаар дуусгавар болно.
- 15.3 Намын даргад дараах болзлыг хангасан намын гишүүн нэр дэвших эрхтэй байна. Үүнд:
 - 15.3.1 Сүүлийн гурван жилийн турш намын гишүүн байгаа;
 - 15.3.2 Намын бүтцийн байгууллагын сонгуульт албан тушаалд дор хаяж нэг сонгуулийн хугацаанд ажилласан;
 - 15.3.3 Сахилгын шийтгэлгүй байх.

15.4 Намын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 15.4.1 Намын ээлжит Их хурлыг 60-аас доошгүй, ээлжит бус Их хурлыг 30-аас доошгүй хоногийн өмнө товлон зарлаж, хэлэлцэх асуудлын жагсаалт бүхий зарыг тэр даруйд намын бүх гишүүдэд хүрэх энэ дүрэмд заасан нийтийн зарын арга хэлбэрээр нээлттэй мэдээлэх, Намын ээлжит их хурал зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах, хурлын дарга, тэргүүлэгчдийг санал оруулах;
- 15.4.2 Төлөөлөгчийн танхимын анхны дарга сонгох хурлыг таваас доошгүй хоногийн өмнө товлон зарлах, зарыг санал таслах эрхтэй гишүүдэд намын цахим системд бүртгэлтэй имейл хаягаар тов гарснаас хойш 24 цагийн дотор хүргүүлэх, хурлыг удирдах, Төлөөлөгчдийн танхимын дарга сонгосон тогтоол батлагдмагц хурал даргалах эрхийг Төлөөлөгчдийн танхимын даргад шилжүүлэх;
- 15.4.3 Намын нийслэлийн Танхимын анхдугаар хурлыг товлон зарлах;
- 15.4.4 Намын гишүүдийн ойлголцол, эв нэгдлийг хангах, намын хөрөнгө босгох үйл ажиллагаанд манлайлан оролцох;
- 15.4.5 Төлөөлөгчдийн танхим, Үнэт зүйлийн зөвлөлд улс төрийн байр суурь, бодлого томъёолох талаар санал оруулах, гарсан судалгаа, зөвлөмжийг үндэслэн намын улс төрийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах;
- 15.4.6 Намын их хурал, Төлөөлөгчдийн танхимын хуралд тогтоолын төсөл санаачилж хэлэлцүүлэх;
- 15.4.7 Маргаан таслах комисс, Менежментийн зөвлөлийн хурлаас болон, Дотоод аудиторын гаргасан дүгнэлт зөвлөмжийг үндэслэн намын дотоод ардчилал, ил тод байдал, шударга байдлыг хангах, сайжруулах;
- 15.4.8 Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;

15.5 Намын даргад дараах үйлдлийг хориглоно:

- 15.5.1 Бүртгэгчид хэн нэгнийг оноож нэр дэвшүүлэх, Төлөөлөгчдийн Танхимын сонгосон Бүртгэгчтэй хамтран ажиллахаас татгалзах, Бүртгэгчийн үйл ажиллагаанд хууль бус шахалт үзүүлэх;
- 15.5.2 Намын санхүү, төсвийг захиран зарцуулах акт баримтад гарын үсэг зурах;
- 15.5.3 Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам оролцох, намаас тус сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудлаар хуулиар тогтоосон хугацаанд холбогдох хурлыг товлон зарлахгүй, товлон зарласан хуралдаа оролцохгүй байх.

- 15.5.4 Аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэх;
- 15.6 Дараах тохиолдолд намын даргыг огцорсонд тооцно: Үүнд:
- 15.6.1 Намын даргад итгэл үзүүлэх эсэх санал хураалтад Төлөөлөгчдийн танхимын нийтгишүүдийн олонх намын даргад итгэл үзүүлээгүй.
- 15.7 Намын дарга дараах нөхцөлийн улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол намын даргыг чөлөөлнө. Үүнд:
- 15.7.1 Нас барсан;
- 15.7.2 Гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял авсны улмаас иргэний эрхээ хязгаарлуулсан;
- 15.7.3 Намын дарга чөлөөлөгдөх, эсхүл намаас гарах хүсэлтээ намын Бүртгэгчид бичгээр гаргасан;
- 15.7.4 Хүнд өвчний улмаас намын үйл ажиллагаанд нэг жилээс доошгүй хугацаанд оролцох боломжгүй болсныг өөрөө буюу гэр бүлийн гишүүний зүгээс Намын Бүртгэгчид хаяглан бичгээр илэрхийлсэн;
- 15.8 Намын дарга, дэд даргын сонгуулийг Дотоод сонгуулийн ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд сонгуулийн тов, нэр дэвшигчийн материал хүлээн авах хугацаа, нэр дэвшигчдэд тавих шаардлагыг агуулсан нийтийн зарыг намын бүх гишүүдэд нээлттэй арга хэлбэртээр дараах хугацаанд багтаан зарлана:
- 15.8.1 Намын ээлжит их хурлаар болох намын дарга, дэд даргын сонгуулийг намын их хурлын тов гарснаас хойш 15 хоногийн дотор;
- 15.8.2 Намын даргыг намын ээлжит бус их хурлаар чөлөөлсөн, эсхүл огцруулсан бол намын даргын сонгуулийг тус ээлжит бус их хурлын үеэр, эсхүл тус хурлаас тогтоосон хугацаанд.
- 15.9 Намын даргыг огцорсонд тооцох, чөлөөлөх нөхцөл үүссэн бол уг нөхцөл үүссэнээс хойш 30 хоногийн дотор Намын дэд дарга намын ээлжит бус их хурлыг товлон зарлана. Хэрэв тус нөхцөл намын ээлжит их хурал болохоос 90 хоногийн дотор үүссэн бол намын дэд дарга намын ээлжит их хурлыг товлон зарлана.
- 15.10 Намын их хурлаар дараагийн намын дарга сонгогдсон тогтоол батлагдмагц намын дэд дарга намын даргыг түр орлох үүрэг дуусгавар болно.
- 15.11 Намын дэд даргыг гурван жилийн хугацаагаар Намын Их Хурлаас нууц санал хураалтаар сонгох ба намын дэд даргыг хамт нэр дэвшсэн намын даргын улиран сонгогдох хугацаанд улируулан сонгож болно. Намын дэд даргын бүрэн эрх

дараагийн дэд даргыг намын Их Хурлаар сонгосон тогтоол батлагдсанаар дуусгавар болно.

15.12 Намын дэд дарга намын даргын бүрэн эрхэд хамаарах асуудлаар намын даргын зөвшөөрөл, итгэмжлэлээр болон энэхүү дүрэмд заасан нөхцөлд түүнийг түр орлоно.

15.13 Намын дэд дарга намын даргатай өдөр тутам багаар хамтран ажиллана.

15.14 Энэхүү дүрмийн 15.5, 15.6 дахь заалтын дагуу хориглох зүйл намын дэд даргад мөн адил хамаарна.

15.15 Намын дэд дарга дараах нөхцөлийн улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол намын дэд даргыг чөлөөлнө. Үүнд:

15.15.1 Нас барсан ;

15.15.2 Гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял авсны улмаас иргэний эрхээ хязгаарлуулсан ;

15.15.3 Намын дэд дарга чөлөөлөгдөх, эсхүл намаас гарах хүсэлтээ намын Бүртгэгчид бичгээр гаргасан;

15.15.4 Хүнд өвчний улмаас намын үйл ажиллагаанд нэг жилээс доошгүй хугацаанд оролцох боломжгүй болсныг өөрөө буюу гэр бүлийн гишүүний зүгээс Намын Бүртгэгчид хаяглан бичгээр илэрхийлсэн.

16 дугаар зүйл. Намын ерөнхий менежер, намын санхүүч, намын ажлын алба

16.1 Намын ерөнхий менежерийг Менежментийн зөвлөл 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий менежерийг 3 хүртэл удаа улируулан ажиллуулж болно.

16.2 Ерөнхий менежер нь төрийн алба, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд давхар алба хашихыг хориглоно.

16.3 Намын ерөнхий менежер нь намын санхүүгийн асуудал эрхэлсэн удирдах ажилтан байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

16.3.1 Намын ажлын албыг удирдах, зохион байгуулах, ингэхдээ энэ дүрмээр намын Төлөөллийн төв, Гүйцэтгэх төв байгууллагаас сонгогдож, томилогдсоноос бусад ажилтныг томилох, чөлөөлөх,

16.3.2 Намын хөрөнгө, санхүүг захиран зарцуулах, намын салбар, бүтцийн байгууллагаас ирүүлсэн төслийг санхүүжүүлэх эсэхийг хэлэлцэж сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

- 16.3.3 Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд төрийн санхүүжилт авах зорилгоор уг санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, санхүүжилт авах тухай хүсэлтийг Намын нэрийн өмнөөс гаргах;
 - 16.3.4 Сонгуульт хугацаандаа аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхгүй байх;
 - 16.3.5 Намын санхүүч (ерөнхий нягтлан бодогч)-ийг томилох ба чөлөөлөх.
 - 16.3.6 Намын санхүүгийн тайланг Сонгуулийн төв байгууллагад хүргүүлэхээс өмнө намын Менежментийн зөвлөлд оруулж хэлэлцүүлэх, тус тайланг Сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх,
 - 16.3.7 Намын санхүүгийн тайланг баталгаажуулж гарын үсэг зурах.
 - 16.3.8 Намын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулах, нэмэлт, өөрчлөлт оруулахаар Менежментийн зөвлөлд оруулж хэлэлцүүлэх.
 - 16.3.9 Монгол улсын Иргэний хуульд нийцсэн Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гүйцэтгүүлэх тухай гэрээг намын ажлын албыг төлөөлөн байгуулах.
- 16.4 Ерөнхий менежер нь намын ажлын албаны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажлын байрны тодорхойлолтыг гаргана. Намын гишүүн намын ажлын албанд сайн дураар ажиллаж, өөрийн ажилласан цагийг мөнгөн бус хандивт тооцуулж болно.
- 16.5 Намын ажлын албаны бүтцэд дараах болон шаардлагатай бусад ажилтан, газар, хэлтэс багтаж болох ба ажлын албаны бүтэц, орон тоог Менежментийн зөвлөл батална.
- 16.5.1 Бүртгэгч;
 - 16.5.2 Намын нарийн бичгийн дарга;
 - 16.5.3 Намын санхүүч/ерөнхий нягтлан бодогч;
 - 16.5.4 Мэдээллийн технологийн ажилтан;
 - 16.5.5 Мэдээлэл сурталчилгааны ажилтан.
- 16.6 Намын ерөнхий менежер нь салбар, танхимын ажлын албыг нэгдсэн удирдлагаар хангана.
- 16.7 Намын ерөнхий менежер нь Маргаан Таслах комисс, Дотоод сонгуулийн ажлын хэсэг, Тандалт үнэлгээний ажлын хэсэг болон бусад ажлын хэсэг, намын дотоод аудиторыг ажиллах нөхцөлөөр хангана.

- 16.8 Намын санхүүч нь намын нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт хөтлөх, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримтыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгалах үйл ажиллагааны гүйцэтгэлийг хангуулж, намын санхүүгийн тайланг нэгтгэж гарын үсэг зурна. Ингэхдээ салбарын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргана.
- 16.9 Намын санхүүч нь намын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг намын хэмжээнд мөрдүүлж ажиллана.
- 16.10 Намын Ажлын алба нь намын нэгдсэн цахим системийг ажиллуулан, уг нэгдсэн цахим системийн тасралтгүй, аюулгүй, найдвартай ажиллагааг хангана.
- 16.11 Мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж түүнд шаардлагатай удирдлагаар хангаж ажиллана.
- 16.12 Намын ажлын албаны дараа жилийн төсвийг Төлөөлөгчдийн Танхим жил бүрийн 12-р сарын 20-ны дотор батална.
- 16.13 Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох талаар намын Төлөөлөгчдийн танхимаас гарсан шийдвэр, хуулиар заасан бусад баримт бичиг, сонгуульд оролцсонтой холбоотой намын санхүү, хандивын тайланг төрийн зохих байгууллагад хугацаанд нь илгээгээгүй нь Ерөнхий менежерийг огцруулах үндэслэл болно.

17 дугаар зүйл. Бүртгэгч

- 17.1 Бүртгэгч нь намын дотоод ил тод байдал, шударга, тэгш байдал, дотоод ардчиллыг хангах чиг үүрэг бүхий сонгуульт, орон тооны, гүйцэтгэх албан тушаал мөн.
- 17.2 Бүртгэгч нь үүрэгт ажлаа гүйцэтгэж байх хугацаандаа намын дотоод сонгууль болон төрийн сонгуульд оролцохгүй.
- 17.3 Бүртгэгч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 17.3.1 Намд элсэхээр бичгээр болон цахимаар өргөдөл гаргасан, аппликэйшнээр хүсэлт ирүүлсэн Монгол улсын иргэнийг өөр улс төрийн намд харьяалалтай эсэхийг лавлах, хөндлөнгийн гэрчээс тодруулга авах, батлан даагчаас баталгаа авах замаар нягталж намын гишүүнээр бүртгэн авах;
- 17.3.2 Намын гишүүдийн орон нутгийн болон статусын шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, намын татвар, дотоод сонгууль зохион байгуулагдаж буй саруудад намын гишүүний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг нэг календарийн жилд гурван сараас илүүгүй хугацаагаар зогсоох

- 17.3.3 Намын аливаа дотоод сонгуулийн өмнө татвар төлөлтийн мэдээг гаргаж, саналын эрхтэй гишүүдийн тоо, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хассан жагсаалтыг дотоод сонгууль зохион байгуулах ажлын хэсэгт нэр дэвшигчийн сурталчилгаа эхлэхээс өмнө хүлээлгэн өгөх;
- 17.3.4 Намын татвар, хуримтлал, хандив хүлээн авах данс, тус данснаас гүйлгээ хийх эрх бүхий этгээд, намын албан бичиг, тогтоол шийдвэрт гарын үсэг зурах эрх бүхий этгээд, тамга, тэмдгийн хэв, намын албан ёсны веб сайт, пэйж, цахим хаягууд, тэдгээрт нэвтрэх эрх эзэмшигч нарын бүртгэлийг тус тус хийж, өөрчлөлтийг шинэчилж байх;
- 17.3.5 Намын дотоод сонгуулиар намын дүрэмд заасан албан тушаал, төлөөллийн, гүйцэтгэх, хяналтын байгууллагад болон түр ажлын хэсэгт сонгогдсон, томилогдсон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа эхэлсэн, дууссан огноог бүртгэх;
- 17.3.6 Бүртгэгч нь мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлан шалгахын тулд намын аль ч шатны байгууллага, албан тушаалтнаас тодруулга авах, намын гишүүдтэй ярилцлага хийх, намын цахим дата баазад нэвтрэх эрхтэй байна.
- 17.3.7 Бүртгэгч нь давхардсан, намаас гарахаа илэрхийлсэн, намаас хасах шийдвэр гарсан, бүрэн эрхийн хугацаа дууссан, нас барсан шалтгаанаар аливаа мэдээллийг жагсаалтаас хасахын өмнө “Бүртгэлээс хасах акт”, алдаатай, ташаа орсон мэдээллийг залруулах, гишүүний статус өөрчлөгдсөн, сахилгын шийтгэлтэй байгаа, сахилгын шийтгэл дууссан шалтгаанаар бүртгэлд засвар хийхийн өмнө “Бүртгэлд өөрчлөлт оруулах акт”, гишүүнийг намаас түдгэлзүүлэхтэй холбоотойгоор “Намаас түдгэлзүүлэх акт”, “Намын гишүүнчлэлийг сэргээх акт” тус тус үйлдэж намын нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч намын архивд хадгалуулна.
- 17.3.8 Бүртгэгч нь намын гишүүний бүртгэлтэй холбоотой хууль, тогтоомжид заасан мэдээ, мэдээлэл гаргахад оролцоно.
- 17.3.9 Бүртгэгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд намын ажлын албанаас цалин, ажлын өрөө, тавилга, тоног төхөөрөмж, бичиг хэргийн болон харилцаа холбооны урсгал зардал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах хэрэгсэл, туслах ажилтан гаргуулан авах эрхтэй.
- 17.4 Бүртгэгчийг Төлөөлөгчдийн Танхимаас 5 жилийн хугацаатай 1 хүнийг нууц санал хураалтаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.
- 17.5 Бүртгэгч нь намын гишүүдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, намын дотоод ардчиллыг бэхжүүлэхэд шаардлагатай хөгжүүлэлтийг намын нэгдсэн мэдээллийн

систем, аппликэйшн, веб сайтад хийхэд нь мэдээллийн технологийн ажилтантай хамтран ажиллана.

18 дугаар зүйл. Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг

- 18.1 Төрийн сонгуульд оролцох Намаас нэр дэвшигчдийг тодруулах болон намын сонгуульт албан тушаалд нэр дэвшигчдийг сонгох дотоод сонгуулийг Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг удирдан зохион байгуулна. Намын дотоод сонгуулийн ажлын хэсэг нь байнгын бус, орон тооны бус гүйцэтгэх байгууллага мөн.
- 18.2 Намын бүх ээлжит дотоод сонгууль тухайн сонгуульт жилийн 03 дугаар сарын 01-ээс 31-ний хооронд багтан зохион байгуулагдана. Үүнд төрийн сонгуульд намаас нэр дэвшигчийг тодруулах хуулиар заасан хугацаа бүхий дотоод сонгууль хамаарахгүй.
- 18.3 Намын дотоод сонгуулийг зохион байгуулах эрх бүхий дотоод сонгуулийн ажлын хэсгийг Төлөөлөгчдийн Танхим байгуулна. Дотоод сонгуулийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь непотизм (эрх ашгийн хамаарал)-аас ангид байх бөгөөд аль нэг салбар, танхимын гишүүдээс дангаар бүрдэж болохгүй.
- 18.4 Дотоод сонгууль, нөхөн сонгуулийг дараах байдлаар хугацаа дууссан, орон гарсан суудалд зарлана. Үүнд:
 - 18.4.1 Бүрэн эрхийн хугацаа нь дууссан;
 - 18.4.2 Сонгуульт албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ намын дарга эсхүл бүртгэгчид бичгээр ирүүлсэн;
 - 18.4.3 Намын дүрэмд заасны дагуу албан тушаалаас огцруулсан;
 - 18.4.4 Гишүүн шүүхээр гэм буруутай нь тогтоогдож эрүүгийн ял шийтгэл хүлээсэн;
 - 18.4.5 Гишүүн намаас гарсан;
 - 18.4.6 Гишүүн нас барсан.
- 18.5 Дотоод сонгуулийн ажлын хэсэг нэг жилийн хугацаатай томилогдох ба дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 18.5.1 Эрх бүхий байгууллагаас товлон зарласан дотоод сонгуульд нэр дэвшигчдийг бүртгэх сул орон тооны жагсаалт гаргаж уг орон тоонд дотоод сонгуульд нэр дэвшилтийг нэр дэвшигчдэд тавих намын дүрэм, журамд заасан болзлын хамт зарлах, нэр дэвшигчдийг бүртгэх, болзол хангаагүй гишүүнийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзан буцаах, нэр дэвшилтийг хаах;
 - 18.5.2 Нэр дэвших өргөдлийн маягт батлах, зарлах;

- 18.5.3 Анхан шатнаас бусад дотоод сонгуульд хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч бүртгэгдсэн бол тандалт үнэлгээний ажлын хэсэг томилуулах хүсэлтийг Намын даргад хүргүүлэх;
 - 18.5.4 Бүх шатны хуралд дотоод сонгуулийн нэр дэвшилтийг танилцуулах, нэр дэвшилт хаасны дараа үлдсэн сул орон тоонд хурал дээр нэр дэвших ажиллагааг зарлах, бүртгэх.
 - 18.5.5 Намын гишүүн саналаа нууцаар, чөлөөтэй гаргах, нэг хүн нэг санал хураалтад зөвхөн нэг удаа санал өгөх нөхцөлийг хангах.
 - 18.5.6 Дотоод сонгуулийн дүнг мэдээлэх
- 18.6 Дотоод сонгууль шударга бус болсон нь Маргаан таслах комиссын дүгнэлтээр тогтоогдож дахин сонгууль явуулах шийдвэр гарсан бол амжилтгүй сонгууль зохион байгуулахад оролцсон ажлын хэсгийн гишүүнийг хугацаанаас өмнө чөлөөлөх ба дахин сонгуулийг зохион байгуулах ажлын хэсэгт оруулахгүй.
- 18.7 Дотоод сонгуулийн ажлын хэсэгт томилогдон ажиллах хугацаанд нь гарсан зардлын баримт, гарах зардлын нэхэмжлэлд үндэслэн ажлын байр, урсгал зардал, гишүүдэд ажлын урамшуулал олгож болно. Энэхүү зардлыг нягталж, гаргах үүргийг намын ажлын алба хариуцна.

19 дүгээр зүйл. Үнэт зүйлийн зөвлөл

- 19.1 Үнэт зүйлийн зөвлөл нь намын улс төрийн бодлогын зөвлөх байгууллага мөн.
- 19.2 Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүнийг Төлөөлөгчдийн танхимын хурлаас 3 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгоно. Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүнд намын гишүүд нээлттэй нэр дэвшиж өрсөлдөнө.
- 19.3 Үнэт зүйлийн зөвлөлийн ээлжит хурал хагас жил тутам хуралдаж олонхын саналаар шийдвэр гаргана. Үнэт зүйлийн зөвлөлийн хурлыг намын дарга, эсхүл ҮЗЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь гарын үсэг зурснаар, эсхүл Намын даргын орон гарсан үед Намын дэд дарга тус тус зарлан хуралдуулна.
- 19.4 Үнэт зүйлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нийгмийн залуу ба ахмад, эрэгтэй ба эмэгтэй, тусгай хэрэгцээт бүлгийн гишүүдийн төлөөллийг жигд оролцуулах үүднээс дараах суудалд сонгоно. Үүнд:
 - 19.4.1 40 ба түүнээс дээш насны 5 эмэгтэй, 5 эрэгтэй;
 - 19.4.2 39 ба түүнээс доош насны 5 эмэгтэй, 5 эрэгтэй;
 - 19.4.3 Тусгай хэрэгцээт гишүүдийн төлөөлөл 1 эмэгтэй, 1 эрэгтэй;
- 19.5 Үнэт зүйлийн зөвлөл нь дараах бүрэн эрх, үүрэгтэй байна.

- 19.5.1 Цаг үеийн улс төрийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, намыг төлөөлж улс төрийн байр сууриар зөвлөмж, мэдэгдэл гаргах, мэдэгдэл гаргахыг намын албан тушаалтанд зөвлөх;
- 19.5.2 Бодлогын болон нийгмийн судалгаа хийх;
- 19.5.3 Намын албан ёсны бүтэц, нийгмийн бүлгийг бодлогын судалгаанд оролцуулах, хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах;
- 19.5.4 Намын нийт гишүүд, намын дотоод сонгуульд нэр дэвшсэн, сонгогдсон гишүүд болон хуримтлал бүрдүүлэгч гишүүдийн дунд намын үнэт зүйл, үзэл баримтлал, дотоод соёлын талаар төлөвлөгөөт сургалт, гишүүдийн ур чадвар хөгжүүлэх, чадавхижуулах чиглэлээр сургалт зохион байгуулах;
- 19.5.5 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагад судалгаа, тандалт захиалах, дүнг хурлаар сонсох.

20 дугаар зүйл. Сонгуульд нэр дэвшүүлэх боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах

- 20.1 Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулах бөгөөд тус журам нь энэхүү зүйлийн хүрээнд дараах гурван үе шатыг хамран зохицуулалт хийнэ.
 - 20.1.1 Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх үе шат
 - 20.1.2 Тандалт, үнэлгээний үе шат
 - 20.1.3 Хуулиар эрх олгогдсон намын байгууллага шийдвэр гаргах үе шат
- 20.2 Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх үе шатанд дараах үйл ажиллагаа багтана:
 - 20.2.1 Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний болзлыг ханган Бүртгэгчид бүртгүүлэх;
 - 20.2.2 Төрийн ээлжит сонгуулийн хооронд хамгийн багадаа 1 удаа хандивлагч гишүүнээр бүртгэгдсэн байх;
 - 20.2.3 Намын мөрийн хөтөлбөрт нийцсэн идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулах, манлайлах, намын гишүүд дунд болон нийгэмд танигдах;
- 20.3 Тандалт, үнэлгээний үе шатанд дараах үйл ажиллагаа явуулна:
 - 20.3.1 Намын гишүүн тандалт үнэлгээнд зориулсан хувийн тайлан гаргаж Тандалт үнэлгээний ажлын хэсэгт тогтоосон хугацаанд илгээнэ.
 - 20.3.2 Тандалт үнэлгээний ажлын хэсэг гишүүдийн хувийн тайлан, хөндлөнгийн мэдээлэл, маргаан таслах комиссын тогтоол зэргийг үндэслэн тоон үзүүлэлтээр гишүүдийг эрэмбэлнэ.
 - 20.3.3 Тандалт үнэлгээний ажлын хэсэг өрсөлдөгч гишүүдийн талаар холбогдох салбар танхимын гишүүдээс, санал тэнцсэн тохиолдолд хандивлагч гишүүдээс тус тус санал асуулга авч болно.
- 20.4 Хуулиар эрх олгогдсон намын байгууллага шийдвэр гаргах үе шатанд тухайн сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан Монгол улсын хууль, намын Төлөөлөгчдийн

- танхимаас баталсан төрийн сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохицуулах тусгай журмыг мөрдөж ажиллана.
- 20.5 Энэхүү дүрмийн 20.2-т заасны дагуу өөрийгөө илэрхийлсэн гишүүдэд намын гишүүдтэй холбогдох хаяг, мэдээллийг тэгш хүргэх үүргийг Намын ажлын алба хүлээх ба хууль эрх зүй, сонгуулийн кампанит ажил зохион байгуулах арга зүйн сургалтыг намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага эрхлэн явуулна.
- 20.6 Намын эрх бүхий байгууллага төрийн сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд багтаж энэ дүрмийн 20.2-т заасны дагуу бүртгэгдсэн гишүүдийн дотроос 20.3-т заасан тандалт, үнэлгээний дүнд үндэслэн нэр дэвшүүлнэ.
- 20.7 Намаас төрийн сонгуульд нэр дэвшигчдийн дотор эрэгтэй, эмэгтэй аль нэг хүйсийн төлөөлөл хуульд өөрөөр заагаагүй бол 30 хувиас багагүй байна.
- 20.8 Сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээс барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авахыг хориглоно.

21 дүгээр зүйл. Маргаан Таслах Комисс

- 21.1 Маргаан таслах комисс нь намын хяналтын байгууллага мөн. Маргаан таслах комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 21.2 Маргаан таслах комисс 9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба шинээр сонгогдсон бүрэлдэхүүний анхны хурлыг хамгийн ахмад гишүүн удирдаж, гишүүдийн олонхын саналаар тус комиссын даргыг нууц санал хураалтаар сонгоно. Маргаан таслах комиссын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байна. Төлөөлөгчдийн танхим, Менежментийн зөвлөлийн гишүүн, намын ажлын албаны ажилтан нь Маргаан таслах комиссын гишүүн байж болохгүй.
- 21.3 Маргаан таслах комисс цахим болон боломжит хэлбэрээр хуралдана. Маргаан үүсгэсэн нөхцөл байдлыг баримтжуулах үүргийг маргаан үүсгэгч талууд хариуцах бөгөөд маргаан таслах комисс нотлох баримт бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй.
- 21.4 Маргаан таслах комисс хуралдаж олонхын саналаар шийдвэр гаргана. Маргаан таслах комиссын хуралд комиссын гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. Маргаан таслах комиссын маргаан хянан шийдвэрлэх журмыг энэ дүрэмд нийцүүлэн Төлөөлөгчдийн танхим батална.
- 21.5 Маргаан таслах комисс нь Монгол Улсын улс төрийн намын тухай хууль, энэхүү дүрмийн хүрээнд хараат бус ажиллах бөгөөд Маргаан таслах комиссын гишүүнд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

- 21.6 Маргаан таслах комисст гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа нь гомдол гаргах үйлдэл, эс үйлдэл болсноос хойш 30 хоногт байна.
- 21.7 Маргаан таслах комисст гомдол гарсны дараа маргагч талууд дараах эрхтэй байна. Үүнд:
 - 21.7.1 Маргаан таслах комисст тайлбар гаргах;
 - 21.7.2 Нотлох баримт гаргаж өгөх;
 - 21.7.3 Маргааныг шийдвэрлэх хуралдаанд биечлэн оролцох.
- 21.8 Маргаан таслах комисс дараах бүрэн эрхтэй:
 - 21.8.1 Маргаан таслах комиссын хуралд биеэр оролцох зар хүлээн авсан ч ирээгүй тохиолдолд талуудын оролцоогүйгээр хурлыг хуралдуулах эсэх шийдвэр гаргах;
 - 21.8.2 Маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх;
 - 21.8.3 Дүгнэлт, зөвлөмж гаргах;
 - 21.8.4 Намын дүрмийн 4.7-д заасан үндэслэлээр намын гишүүнд намаас хасахыг сануулах, намаас төрийн сонгуульд нэр дэвших эрхийг нэг сонгуулийн жил хасах, эсхүл хасахыг сануулах, намын дотоод сонгуульд нэр дэвших эрхийг 1-3 жил хасах, намаас хасах сахилгын шийтгэл ногдуулах.
- 21.9 Маргаан таслах комиссын ажлын байр, ажлын хөлс, бусад урсгал зардлыг Намын ажлын алба хариуцна.
- 21.10 Маргаан таслах комиссын дарга дараах бүрэн эрхтэй:
 - 21.10.1 Маргааны өргөдөл хүлээн авах, өргөдлийг илтгэгч гишүүнд хуваарилах;
 - 21.10.2 Маргаан үүсгэх, маргаан үүсгэхээс татгалзах;
 - 21.10.3 Маргаан таслах комиссын хурал товлон зарлах, удирдах;
 - 21.10.4 Маргаан таслах комиссын шийдвэрт нэгдүгээр гарын үсэг зурах.
- 21.11 Маргаан таслах комиссын гишүүн өөрт хуваарилагдсан өргөдөл, гомдол, хүсэлт ба хавсарган ирүүлсэн нотлох баримтыг судалж, тус маргааны хариуцагч талд ирсэн гомдол маргааны талаар ажлын 3 хоногийн дотор мэдэгдэж, хариу тайлбар гаргуулан, хоёр талын байр суурийг Улс төрийн намын тухай хууль, ИОН намын дүрэм, журмын хүрээнд нягталсны дараа маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр төлөвлөх, маргаан үүсгэсэн тохиолдолд Маргаан таслах комиссын хуралд танилцуулга бэлтгэх, маргаан таслах комиссын хурлын зарыг талуудад ижил аргаар ижил өдөрт илгээх, тус хариуцсан өргөдлийн талаар Маргаан таслах комиссын хурлаас гарсан шийдвэрт хоёрдугаар гарын үсэг зурах эрх, үүрэгтэй.
- 21.12 Маргаан таслах комисс намын гишүүн, салбар, танхим, бүтцийн байгууллагаас дор дурдсан үндэслэлээр гомдол хүлээж авна.

- 21.12.1 Намын дүрэм зөрчсөн эсэх;
 - 21.12.2 Нам болон намын гишүүний хооронд үүссэн;
 - 21.12.3 Намын дотоод сонгуультай холбогдон үүссэн;
 - 21.12.4 Намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой.
- 21.13 Маргаан Таслах Комиссын дарга гомдол хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор илтгэгч гишүүнд хуваарилах бөгөөд, 30 хоногийн дотор маргаан үүсгэх эсэх шийдвэрийг гомдол гаргагчид мэдэгдэнэ. Маргаан үүссэнээс хойш 15 хоногийн дотор маргаан таслах комиссын хурлыг товлон, маргалдагч талуудад хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө намын цахим системд бүртгэгдсэн утас, имейл хаягаар зарыг хүргэнэ.
- 21.14 Маргаан таслах комиссын дүгнэлт зөвлөмжөөс бусад шийдвэр гарснаас хойш гомдол гараагүй үед 16 дахь, гомдол гарсан үед тухайн гомдлыг шийдсэнээс хойш 15 хоногийн дараа хэрэгжинэ. Дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацааг тухайн зөвлөмж тус бүрд зааж оруулна.
- 21.15 Маргаан таслах комиссын шийдвэрийг талууд эс зөвшөөрвөл 15 хоногийн дотор тус комисст дахин хянаж үзэхийг хүссэн гомдол гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд илтгэгч гишүүнийг өөрчилж томилно.
- 21.16 Маргаан таслах комиссын шийдвэрээр сахилгын шийтгэл хүлээсэн намын гишүүнийг уг сахилгын шийтгэлийн хугацаа дуусмагц сахилгын шийтгэлгүйд тооцно.
- 21.17 Маргаан таслах комисс хүний суурь эрх, эрх чөлөөнд халдсан асуудал авч хэлэлцэхгүй бөгөөд суурь эрх, эрх чөлөөнд халдсан санал хураалт явуулахгүй.
- 21.18 Маргаан таслах комисс энэ дүрмийн 4.7.9-д заасан хөөн хэлэлцэх хугацаанд багтааж маргаан үүсгэнэ. Хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн гомдлоор маргаан үүсгэхгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НАМЫН САНХҮҮЖИЛТ

22 дугаар зүйл. Намын хөрөнгө, орлого

- 22.1 Намын эд хөрөнгөд үл хөдлөх хөрөнгөөс бусад дараах төрлийн эд хөрөнгө байна.
- 22.1.1 Гишүүний татвар;
 - 22.1.2 Гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулиар хориглосноос бусад хуулийн этгээдээс өгсөн хандив;
 - 22.1.3 Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;

- 22.1.4 Намын бэлгэдэл, оюуны өмч бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс, намын оюуны өмч шингэсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлогоос ногдох хувь;
- 22.1.5 Намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого;
- 22.1.6 Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого;
- 22.1.7 Намын мөнгөн хөрөнгийг банканд хадгалуулсны хүү.
- 22.2 Нам компани болон бизнесийн бусад байгууллагад хувь эзэмшихгүй

23 дугаар зүйл. Намын орлогын зарцуулалт

- 23.1 Намын орлогыг зөвхөн намын мөрийн хөтөлбөр, дүрмээр болон Улс төрийн намын тухай хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулахад зарцуулна.
- 23.2 Намын орлогыг энэ дүрмийн 23.1-д зааснаас өөр зүйлд зарцуулах, гишүүдэд ногдол ашиг болгон хуваарилахыг хориглоно.
- 23.3 Намын үйл ажиллагаанд орлогыг зарцуулахдаа зорилтот үр дүнд хүрэх хамгийн хэмнэлттэй хувилбарыг сонгох зарчмыг баримтална.
- 23.4 Намын санхүүжилтийг дүрмийн бус зүйлд зарцуулсан талаар намын гишүүн Маргаан Таслах Комисст гомдол гаргах эрхтэй.
- 23.5 ИОН нам хуулийн дагуу төрөөс санхүүжилт авах тохиолдолд намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна:

23.5.1 Төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх, ингэхдээ тус дүнгийн 34-өөс доошгүй хувийг намын дэргэдэх Бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд;

23.5.2 Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах, ингэхдээ тус дүнгийн 34-өөс доошгүй хувийг намын дэргэдэх Бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд;

23.5.3 Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх, ингэхдээ тус дүнгийн 34-өөс доошгүй хувийг намын дэргэдэх Бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд тус тус зарцуулна.

- 23.6 Энэ дүрмийн 23.5.1, 23.5.2, 23.5.3-д заасан чиглэлээр төсөл хэрэгжүүлэх хүсэлтэй намын дараах бүтцийн байгууллага болон гишүүдийн сонирхлын бүлэг, клуб нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг авахаар хүсэлт гаргаж болно. Үүнд:

23.6.1 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага

23.6.2 Нийслэл, дүүрэг, аймгийн танхим

23.6.3 Сум, хорооны салбар

23.6.4 Намын Бүртгэгчид бүртгэгдсэн гишүүдийн сонирхлын бүлэг, клуб.

23.7 Энэхүү дүрмийн 23.6-д заасан этгээдээс намын төв ажлын албанд ирүүлсэн төслийг Менежментийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргахдаа тус дүрмийн 23.5-д заасан хувь харьцааг баримтлах бөгөөд энэ дүрмийн 23.5.1, 23.5.2, 23.5.3-д зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

24 дүгээр зүйл. Гишүүний татвар, намд өгөх хандив

24.1 Намын гишүүний жилийн татварыг Төлөөлөгчийн Танхимаас тогтоосон хэмжээгээр, хуримтлал бүрдүүлэгч гишүүний жилийн татварыг өмнөх жилийн нийт хуримтлалын 1 хувиас хэтрэхгүй, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас илүүгүй хэмжээгээр гишүүн өөрөө тогтоож намын дансанд дараах хуваарийн дагуу төлнө.

24.1.1 Дотоод сонгуулийн өмнөх татвар төлөлт: 2 дугаар сарын 1-ний дотор;

24.1.2 Дотоод сонгуулийн дараах татвар төлөлт: 4 сарын 1-нээс 12 сарын 10-ны дотор;

24.1.3 Хуримтлал бүрдүүлэгч гишүүний татвар төлөлт: сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүн тандалт үнэлгээний хувийн тайлангаа энэ дүрмийн 20.3.1 дэх заалтын дагуу илгээхээс өмнө.

24.1.4 Ээлжит дотоод сонгууль товлогдоогүй үед татвар төлөлт жилийн бүх сард нээлттэй байна.

24.2 Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Мөнгөн хандивыг намын дансаар хүлээн авна. Мөнгөн бус хандивыг хүлээн авсан намын ажлын албаны ажилтан нь бичгээр гэрээ, актын аль нэгийг үйлдэж намын санхүүд хүлээлгэн өгнө.

24.3 Намд зориулж иргэн, аж ахуйн нэгжээс өгөх хандивын хэмжээ нь Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу байна. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно.

24.4 Нам авсан хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна.

24.5 Гишүүний татвар болон хандивыг тооцооны нэг дансанд байршуулна. Энэхүү дансыг намын төв болон салбарын Ажлын Алба намын Бүртгэгчид бүртгүүлж, жил бүр дансанд хөндлөнгийн аудит хийлгэнэ.

24.6 Сонгуулийн үйл ажиллагаанд зориулж намд хандив авах, зарцуулах, тайлан гаргах үйл ажиллагааг сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна.

24.7 Дараах этгээдээс хандив авахыг хориглоно:

24.7.1 арван найман насанд хүрээгүй Монгол Улсын иргэн;

- 24.7.2 төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага, лиценз эзэмшдэг, төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэдэг аж ахуйн нэгж;
 - 24.7.3 шашны байгууллага;
 - 24.7.4 олон улсын байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн;
 - 24.7.5 байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд;
 - 24.7.6 тодорхой нэр хаяггүй этгээд;
 - 24.7.7 дамбуурсан болон банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд;
 - 24.7.8 Хуулиар хориглосон бусад этгээд.
- 24.8 Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, гишүүний татвар, хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого, мөн Улс төрийн намын тухай хуулиар зөвшөөрсөн бусад орлогыг цахим мөнгөөр хүлээн авахгүй.
- 24.9 Намын орон нутгийн салбар, танхим намын данснаас санхүүжилт хуваарилуулан авч зарцуулах зориулалт бүхий данстай байж болно. Салбар, танхимын дарга тус дансыг нээлгэснээс хойшхи аливаа гүйлгээ хийхээс өмнө намын Бүртгэгч, намын Санхүүч нарт дансыг бүртгүүлнэ.
- 24.10 Намын гишүүн гишүүний жилийн татвараа төлөөгүй нь тухайн татварын жилд дараах үр дагавар үүсэх үндэслэл болно. Үүнд:
- 24.10.1 Тухайн жилд явагдах намын дотоод сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхгүй байх;
 - 24.10.2 Төрөөс санхүүжилт хүсч санаачилсан төслийг Менежментийн зөвлөлийн хурлаар тухайн жилд хэлэлцүүлэхгүй байх;
 - 24.10.3 Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахаар санаачилсан төслийг тухайн татварын жилд хэлэлцүүлэхгүй байх.

25 дугаар зүйл. Намын үйл ажиллагааг төлбөрийн чадварт нийцүүлэх, намын гишүүдийн оролцоог хангах

- 25.1 Намын бүх шатны хурлыг дан цахимаар, бүх гишүүд биечлэн оролцох, эсхүл цахим ба биечлэн оролцооны холимог хэлбэрийн аль бага өртөгтэй, нийтийн эрүүл мэндэд аюулгүй, оролцооны хувь өндөртэй байдлаар нь зохион байгуулна.
- 25.2 Намын гишүүний нэг жилийн татварыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хүртэл хувиар тогтооно.
- 25.3 Хуримтлал бүрдүүлэгч гишүүний жилийн татварын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна.

- 25.4 Хөдөлмөрийн чадвараа 30 хувиас дээш хэмжээгээр алдсан бол гишүүний татварыг энэ дүрмийн 25.2-т заасан дүнгийн 50 хувиар тооцно. Хөдөлмөрийн чадвар сэргээн тогтоосон бол энэ тухай мэдэгдэж нийтлэг дүнгээр татвараа төлнө.
- 25.5 Намын нийтийг хамарсан арга хэмжээ олонх гишүүдийн төлбөрийн чадварт нийцэхүйц төлбөртэй байж болно. Гишүүдийн олонхын төлбөрийн чадвараас давсан өндөр үнэтэй арга хэмжээг намын нэрээр, эсхүл намын далбаа, бэлгэдэл ашиглан зохион байгуулахыг хориглоно.
- 25.6 Намын өдөр тутмын үйл ажиллагаа, бүртгэл, нийтийн зар, дотоод сонгууль, тандалт судалгаанд цахим технологи голлон ашиглана.
- 25.7 Намын дүрэм, хөтөлбөр батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, сонгуулийн нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж саналыг сонсоно. Энэхүү үйл ажиллагааг тус асуудлыг намын зохих хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг, намын анхан шатны салбар, дунд шатны танхим, намын бодлого судалгааны байгууллага, дүрэм, хөтөлбөрт санал гаргахаа илэрхийлж намын ажлын албанд бүртгүүлсэн аливаа гишүүн, намын ажлын алба, намын сонгуульд албан тушаалтнаас тус тус зохион байгуулж болно.
- 25.8 Намын гишүүн намын дотоод сонгуульд нэрээ дэвшүүлэхээр Дотоод сонгуулийн ажлын хэсэгт материалаа хүлээлгэн өгч нэр дэвшигчээр бүртгэгдсэн мөчөөс эхлэн намын Бүртгэгчээс санал таслах эрхтэй гишүүдийн жагсаалтыг авч, дотоод сонгуулийн сурталчилгааг сонгогч гишүүдийн дунд зохион байгуулах, намын гишүүдийн санал сонсох уулзалтыг намын далбаа, бэлгэдэл ашиглан зохион байгуулах эрхтэй байна.

26 дугаар зүйл. Намын дотоод аудит, санхүүгийн тайлан

- 26.1 Намын үйл ажиллагаа, санхүүд дотоод аудитор тогтмол хяналт тавина.
- 26.2 Үйл ажиллагаа, санхүүгийн тогтмол хяналтыг хэрэгжүүлэх механизм нь Менежментийн зөвлөлийн хуралд дотоод аудиторын хяналт шалгалтын дүнг танилцуулах мэдээлэл юм.
- 26.3 Энэ дүрмийн 26.2-т заасан мэдээллийг Менежментийн зөвлөлийн хуралд оруулах товыг дотоод аудитор Ерөнхий менежерт санал болгох ба Ерөнхий менежер товыг эцэслэн тогтоож, хэлэлцэх асуудалд хамаарал бүхий намын гишүүн, ажилтанд хуралд оролцох зарыг хүргэнэ.
- 26.4 Энэхүү дүрмийн 26.3-т заасан хуралд хэлэлцэж буй асуудлаар мэргэшсэн шинжээчийг оролцуулж болно.
- 26.5 Намын санхүүгийн тайланг Улс төрийн намын тухай хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, стандартад заасан журмын дагуу гаргана. Ажлын Алба салбарын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргана

- 26.6 Нам санхүүгийн үйл ажиллагаандаа энэ дүрэмд заасны дагуу жил бүр хөндлөнгийн санхүүгийн аудит хийлгэж, аудитаас гарсан дүгнэлтийг нийтэд мэдээлнэ. Ингэхдээ Аудитын тухай хууль, тогтоомжийг баримтална.
- 26.7 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн болон нөхөн сонгуулийн зардлын тайланг гаргахтай холбогдох харилцааг сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна.
- 26.8 Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний хуримтлалын дансыг дотоод сонгууль болон төрийн сонгуулиас бусад хугацаанд битүүмжтэй байлгаж, зарлага гаргахгүй ба хуульд заасан хэмжээгээр, хуулиар хориглоогүй этгээдээс хандив авахад дотоод аудитор хяналт тавьж ажиллана.
- 26.9 Дотоод аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Менежментийн зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэр, хугацаатай төлөвлөгөөний хэрэгжилтийг Намын ерөнхий менежер дэс дараатай хангуулна.
- 26.10 Намын салбар, танхимын санхүүгийн тайланд алдаа, зөрчил байсан нь намын дотоод аудитор, хөндлөнгийн аудит, эсхүл төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн тайлан гаргасан намын ажилтан, салбар, танхимын дарга аудиторын тогтоосон хугацаанд алдаагаа засаж, тайлангаа шинэчлэн Намын ажлын албанд ирүүлнэ.
- 26.11 Энэ дүрмийн 26.10-д заасан засвар, шинэчилсэн тайланг намын салбар, танхим холбогдох аудиторын заасан хугацаанд багтаан Намын ажлын албанд ирүүлээгүй, алдаагаа засаагүй бол Намын ерөнхий менежер дараах арга хэмжээг дор дурдсан дэс дараагаар авна. Үүнд:
- 26.11.1 Тайланг шинэчлэн гаргахад нь мэргэжлийн тусламж үзүүлэх гишүүнийг хугацаатай томилж ажиллуулах ;
- 26.11.2 Тухайн салбар, танхимд алдаагаа засах хүртэл намаас санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй байх ;
- 26.11.3 Тухайн салбар, танхимын тайлан хоцорсноос үүдэн намын санхүүжилтийг гурван сараас дээш хугацаагаар зогсоосон тухай салбар, танхимын нийт гишүүдэд намын аппликэйшнээр мэдэгдэл илгээх.
- 26.12 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага энэхүү дүрэм болон хуульд заасан үйл ажиллагааны, санхүүгийн тайланг гаргаагүй, алдаа, зөрчилтэй тайлан гаргасныг аудиторын заасан хугацаанд засаагүй эсхүл шинэчилж тайлан хүргүүлээгүй бол тайлангийн алдаа, зөрчил арилтал ИОН намаас аливаа санхүүжилтийг тус байгууллагад олгохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ, ШИЙДВЭР ГАРГАЛТ

27 дугаар зүйл. Нийтийн зар, хурлын ирц, санал хураалтын горим, хурал удирдах

- 27.1 Энэ дүрэмд заасан намын хурал, дотоод сонгууль, намын аливаа шийдвэрийн төслийн хэлэлцүүлэг, намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалттай холбоотой үйл ажиллагааны аливаа зарыг нийтийн зар гэнэ. Намын доторх сонирхлын бүлгүүдийн уулзалт цугларалт, тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ зэрэгт хамаарах зар нь нийтийн зард тооцогдохгүй.
- 27.2 Нийтийн зарыг тухайн үйл ажиллагаанд таслах эрхтэй бүх гишүүнд ижил арга хэрэгслээр, ижил хугацаанд, Дотоод сонгуульд нэр дэвшигч бүрд хамааралтай хурал, бүртгэлийн зарыг ижил арга хэрэгслээр, ижил хугацаанд тус тус түгээнэ. Ижил хугацааг хангахад техникийн хязгаарлагдмал байдал нөлөөлж буй үед өдөр бүр зар хүргэсээр бүх гишүүнийг хамруулах хүртэлх календарийн өдрүүдийг хамтад нь “ижил хугацаа” гэж тооцно.
- 27.3 Нийтийн зарыг бүх гишүүдэд түгээх үндсэн арга хэрэгсэл нь намын веб сайт, намын аппликэйшн, намын албан ёсны сошиал пэйж хаяг байна. Эдгээр арга хэрэгслийн аль нэгээр буюу эсхүл хослуулсан хэлбэрээр нийтийн зарыг түгээнэ.
- 27.4 Нийтийн зарыг тодорхой салбарын гишүүд, эсхүл намын бүтцийн байгууллагад сонгогдсон гишүүдийн хүрээнд түгээхдээ энэ дүрмийн 27.3-т заасан хэлбэрээр зар түгээсэн эсэхээс үл хамааран намын аппликэйшнд бүртгүүлсэн имэйл хаяг руу захидал бичих, утасны дугаарт мессеж илгээх, утсаар ярих, цахим группт зар түгээх, биечлэн уулзаж зарлах хэлбэрээс дор хаяж хоёр хэлбэрийг ашигласан бол гишүүнд зарыг хүртээмжтэй хүргэсэн гэж үзнэ.
- 27.5 Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол намын гишүүнд нийтийн зарыг хүртээмжтэй хүргэсэн тохиолдолд намын аливаа хурлыг ирсэн ирцээр хуралдуулна. Ирсэн ирц гэж биечлэн танхимд ирсэн хүний тоо, цахимаар холбогдож оролцсон хүний тоо, намын албан ёсоор хэрэглэж буй цахим систем ашиглан саналаа өгсөн хүний тооны давхардаагүй нийлбэрийг хэлнэ.
- 27.6 Хэрэв хуралд оролцвол зохих гишүүнд зарыг хүртээмжтэй хүргээгүй нь тогтоогдвол дараах арга хэмжээний аль нэгийг авна:
- 27.6.1 Хурлыг ирсэн ирцээр эхлүүлж, хурлын зар бүрэн хүрээгүй шалтгааныг зар аваагүй хүн нэг бүр дээр дурдаж тэмдэглэл хөтлөн бүртгэлийн үнэн зөв байдлыг тодруулахаар Бүртгэгчид хүргүүлэх;
- 27.6.2 Хурлыг нэг удаа хойшлуулж, зарыг бүрэн хүргэх арга хэмжээг авах;
- 27.7 Намын дотоод сонгууль, намын хурлын шийдвэрийн санал хураалт нь цахим систем ашиглан, цаасаар, гар өргөж саналаа өгөх, хурлын дэгээр батлагдсан утасны дугаарт мессеж илгээж санал өгөх гэсэн горимын аль нэгээр болон хосолмол хэлбэрээр явагдана.
- 27.8 Хурлын шийдвэр, сонгуулийн үр дүн нь санал хураалтад оролцсон гишүүдийн олонхын саналаар батлагдана. Цөөнхийн саналыг хэлэлцэх боломжийг хурлын дэгээр олгоно.
- 27.9 Санал хураалт нь цахим систем ашиглах, цаасаар санал хураалт явуулах горимоор хэрэгжиж байгаа тохиолдолд уг санал хураалтыг зохион байгуулж буй этгээд санал хураалтад оролцох эрх бүхий гишүүдэд саналаа урьдчилж өгөх боломж гаргана.

- 27.10 Энэ дүрмийн 27.9-д заасан урьдчилсан санал хураалт нь дотоод сонгууль, хурлын товлосон хугацаанаас 72 хүртэлх цагийн өмнө эхэлж, санал хураалт хаах хүртэл үргэлжилж болно.
- 27.11 Энэ дүрэмд тусгайлан зааснаас бусад тохиолдолд намын хурлыг товлон зарласан албан тушаалтан, гишүүн удирдана.

28 дугаар зүйл. Намын дүрэм, хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаа

28.1. Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах санал, санаачилгыг намын гишүүн, намын орон нутгийн салбар, танхим, намын бүтцийн байгууллага, албан тушаалтан, сонгуульт гишүүн гаргаж болох бөгөөд тухайн санал, санаачилгыг дараах горимын дагуу бэлтгэнэ. Үүнд:

- 28.1.1 Санал гаргах. Санал гаргах шатанд тухайн саналын анхны томъёолол болон санал гаргах болсон үндэслэл, энэхүү саналыг дэмжсэнээр гарах эерэг болон сөрөг үр дагаварыг томъёолж бичнэ. Ингэхдээ энэхүү саналын үр дүнд эрх ашиг нь хөндөгдөх субъектийг жагсаасан байна.
- 28.1.2 Төсөл боловсруулах. Энэ шатанд тухайн шинэ санал, санаачилга нь Монгол улсын хуульд нийцсэн, хүчин төгөлдөр дүрмийн бусад заалттай зөрчилдөөгүй, давхардал үүсгээгүй, ИОН намд нэгэнт тогтсон үнэт зүйл, үзэл баримтлал, дотоод соёлыг дордуулаагүй байхаар боловсруулна.
- 28.1.3 Хэлэлцүүлэг зохион байгуулах. Төслийг санаачлагч нь намын гишүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж төсөлдөө гишүүдээс санал авсан байна. Ингэхдээ эрх ашиг нь хөндөгдөж буй субъектийн төлөөллөөс санал авч төсөлд хавсаргана.
- 28.2 Төслийг намын их хурал, Төлөөлөгчдийн танхимын хурлын аль нэгээр энэ дүрмийн шаардлагад нийцүүлэн намын дарга оруулж хэлэлцүүлнэ. Төслийг эрх бүхий байгууллага хэлэлцэх үеэр тус төслийн төслийн санаачлагч хуралд оролцож, асуултад хариулна.
- 28.3 Дүрэм, хөтөлбөрийн төслийг холбогдох хурлаар хэлэлцэхдээ зүйл, заалт бүрээр хэлэлцэж, төслийг батлах эсэх санал хураалт явуулна. Хуралд оролцсон гишүүдийн олонх төслийг батлахыг дэмжсэнээр дүрэм, хөтөлбөрийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл. Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх, намын салбарыг татан буулгах

- 29.1 Намыг өөрчлөн байгуулах, намыг татан буулгах, өөр намтай нэгдэх талаар намын гишүүний бичгээр гаргасан саналыг тухайн санал гаргах өдрийн байдлаар намд бүртгэлтэй гишүүдийн 20-иос доошгүй хувь нь гарын үсэг зурж дэмжсэн бол Намын дарга ээлжит бус их хурал зарлан хуралдуулна.
- 29.2 Энэ дүрмийн 29.1-д заасны дагуу хуралдсан Намын Их Хурлын төлөөлөгчдийн тавны дөрвийн саналаар намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр намтай нэгдэх эсэх асуудлыг шийднэ.

- 29.3 Нам нь үзэл баримтлал, үнэт зүйлийн давхцалын хувьд 80% -д, дотоод ардчилал ил тод байдал нь ойролцоо буюу ижил түвшинд хүрээгүй аливаа намтай нэгдэхгүй.
- 29.4 Энэ дүрмийн 29.16, 29.2-т заасны дагуу өөр намтай нэгдэх асуудлыг ээлжит бус их хурлаар Намын дарга хэлэлцүүлэхдээ намын нэр, бэлгэдэл, намын дүрмийн өөрчлөлтийн гол агуулгын талаар нэгдэхээр төлөвлөж буй намтай (намуудтай) хэрхэн зөвшилцсөн тухай мэдээлэл, холбогдох бичиг баримтыг хуралд танилцуулна.
- 29.5 Намын салбар бүхий сум, хорооны бүх гишүүд намын бүртгэлээс хасагдсан бол Бүртгэгч энэ тухай Намын даргад мэдэгдэж “салбар татан буулгах тухай” хүсэлт бичгээр гаргана. Бүртгэгчийн хүсэлт, мэдээллийг үндэслэж намын салбарыг татан буулгах тухай тушаалыг намын дарга гаргана.
- 29.6 Намын танхим бүхий аль нэг аймаг, дүүрэгт байгуулагдсан бүх салбар татан буугдсан бол тухайн аймаг, дүүргийн танхимыг, нийслэлийн бүх дүүрэгт намын танхим татан буугдсан бол нийслэлийн танхимыг татан буулгах тушаалыг намын дарга гаргана.
- 29.7 Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах, өөр байгууллагатай нэгдэх шийдвэрийг тус байгууллагын дүрмээр зохицуулна. Намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага өөрөө татан буугдсан бол энэхүү дүрмийн дагуу байгуулагдсан намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагыг нам шинээр баталж бүртгэж авна.
- 29.8 Намын үйл ажиллагааг зогсоон татан буулгах тухай шийдвэрийг намын их хурал гаргаснаас хойш Намын дарга ажлын 10 өдрийн дотор Улсын дээд шүүхэд тухайн шийдвэрийг хүргүүлнэ.
- 29.9 Намын үйл ажиллагааг зогсоох, татан буулгах шийдвэр гаргасан намын их хурлаас намыг татан буулгах комиссыг байгуулна. Татан буулгах комисс намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

30 дугаар зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох

- 30.1 Энэхүү дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр Улсын Дээд Шүүхэд 2025 оны 11 сарын 3-ны дотор хүргүүлэх бөгөөд энэхүү дүрэм улсын бүртгэлд бүртгэгдмэгцээ хүчин төгөлдөр болно.
- 30.2 Энэхүү Дүрмийг Монгол хэлээр 2 эх хувь үйлдэж, нэг хувийг Монгол Улсын Дээд шүүхэд хадгалуулав.
- 30.3 Дүрмийн нэг эх хувийг “Монгол Улсын Дээд Шүүх”-д бүртгэсний дараа нөгөө эх хувиас үндэсний бичигт хөрвүүлэх, баррель үсгээр хэвлэх, сонсдог эх хувь бэлтгэх, англи хэл рүү орчуулах ажлыг тус тус Намын Ажлын Алба хариуцаж зохион байгуулна.